

ОРШИЛ ХЭСЭГ

Майк Доттридж

Хүн худалдаалах асуудлаарх НҮБ-ын шинэ конвенци 2000 онд батлагдсанаас хойш эл явдлыг таслан зогсооход чиглэсэн хүчин чармайлтад олон зуун сая доллар зарцуулжээ. Ийнхүү зардал гаргасны цаад санаа нь сайхан боловч олонхи тохиолдолд гаргасан зардлын үр дүн тийм ч олигтой байсангүй. Хүн худалдаалах явдлыг таслан зогсоох зарим санал санаачилга үүний ашгийг хүртэх ёстой хүмүүстээ хүрч чадахгүй, үр дүнгээ өгөхгүй байгаад хүний эрхийг хамгаалагчид болон бусад этгээдийн сэтгэл зовниж байсан. Үнэндээ энэхүү сэтгэл зовнил нь хүн худалдаалах болон хүний эрхийн талаар 2002 оны эхээр батлан гаргасан багц зөвлөмж, удирдамжид тод томруун тусгалаа олсон тэр үед хүн худалдаалахын эсрэг бүхий л арга хэмжээний гол зарчим нь “хүний эрх болон хүний эрхэм чанар, нэн ялангуяа худалдаалагдаж хохирсон хүмүүс, шилжин суурьшигчид, дотооддоо байр сэлгэж буй хүмүүс, дүрвэгсэд болон орогнол хүсэгчдийн эрхэд хор хөнөөл учруулахааргүй” байсан хэмээн НҮБ-ын Хүний эрхийн Дээд Комиссар онцлон тэмдэглэсэн.¹

Энэхүү түүвэр бичвэрт тодорхой найман орны туршлагыг тоймлон судалж, хүн худалдаалахын эсрэг авч буй арга хэмжээ эдгээр нутаг оронд амьдарч, ажиллаж буй хүмүүс, тэндээс гадагш буюу тийш шилжин суурьшиж буй хүмүүст ямар нөлөө үзүүлж буйг үнэлэх оролдлого хийлээ. Эдгээр найман орон гэвэл Австрали, Босни ба Герцогевин, Бразил, Энэтхэг, Нигери, Тайланд, Нэгдсэн Вант Улс болон АНУ болно. Энэхүү бичвэрийн бүлэг хэсгүүдэд ард олны хүний эрхэд үзүүлж буй нөлөөнд онцгой анхаарал хандуулсан. Авч хэрэгжүүлсэн санаачилга, арга хэмжээний (зарцуулсан хөрөнгө мөнгөний) үр дүнд хүн амын үлэмж хэсэг өөрсдийн хүний эрхийг илүүтэй сайн эдэлж чадсан уу? Аль эсвэл хүн худалдаалахын эсрэг санал санаачилга олон хувь хүний, тухайлбал хүн наймаалагчид бус, тодорхой хэлбэл хүний наймааны золиос болж зовж шаналж байхыг нь болиулж, үүний эсрэг арга хэмжээ авч туслан дэмжих ёстой хэмээн нийтээр үзэж байгаа хүмүүсийн хүний эрхэд ихээхэн сөрөг нөлөөтэй байв уу?

Өнгөрсөн таван жилийн хугацаанд НҮБ-ын Хүний эрхийн Дээд Коммисар Мэри Робинсон хүн худалдаалахын эсрэг арга хэмжээ хүний эрхэд “сөрөг муу нөлөөтэй байх ёсгүй” гэдгийг засгийн газруудад онцлон анхааруулж байв. Тэрбээр “хүн худалдаалах явдлаас сэргийлэх, түүнтэй тэмцэх, хохирогсдод туслалцаа үзүүлж, тэдний нэр төрийг сэргээж, хохирлыг арилгах хүчин чармайлтын төвд худалдаалагдсан хүмүүсийн хүний эрх байна” гэсэн зарчмыг нэн тэргүүнээ тавьж байна.² Хэдий тийм ч хүн худалдаалах явдлыг таслан зогсоох талаарх даян дэлхийн засгийн газруудын хүчин чармайлтын нэг гол чиглэл нь наймаалагдаж хохирсон хүмүүсийн хүний эрхийг хамгаалахын оронд наймаачдыг нь баривчлан, мөрдөн шалгаж, ял шийтгэл ногдуулахад оршиж байлаа.

Энэхүү хандлага өнгөрсөн хоёр зууны туршид засгийн газруудаас боолчлолыг устгах, албадан хөдөлмөр болон боолчлол маягийн үйл ажиллагааг (түүний нэг нь хүний наймаа мөн) таслан зогсоох хүчин чармайлт гаргах утгаар зөвшөөрөн хүлээж авсан зүйлтэй нь нийцэж байсан юм. Эдгээр засгийн газар олон улсын гэрээ хэлэлцээрт ч, үндэсний хууль тогтоомждоо ч гэсэн ийм төрлийн бусармаг үйл ажиллагааг яаж үндсээр нь таслан зогсоох, ингэхдээ ийм ажиллагаанд өртөгсөдийн хүний эрхийг хэрхэн хамгаалах талаар ярихын оронд боолчлол болон бусад ижил төрлийн буруу үйл ажиллагааг хууль бус хэмээн зарлахыг урьтал болгож байлаа. Ийм хүмүүс нь гэмт хэрэг болоод эрх мэдлээ урвуулан ашигласан үйлдлийн хохирогч байдаг боловч эдгээр хохирогсдын эрхийн байдал гол нь засгийн газруудын зүгээс тэдэнд хүчин мөхөс барьцаалагдагсад гэсэн байдлаар хандаж харьцахад хүргэж байна. Энэхүү түүвэр бичвэрт бид тэднийг “хохирогч” гэхээсээ илүүтэй “худалдаалагдсан хүмүүс” хэмээн нэрлэж байгаа болно. Засгийн газрын олон байгууллага хууль сахиулах, хүний эрхийг тулж дэмжих гэсэн хоёр зорилт нэгэн хөрстэй гэж эргэлзээгүй үзэж байна. Гэхдээ бидэнд бэлхнээ байгаа гэрчлэх баримт харуулж буйгаар тухайлбал шилжин суурьшигчид, дотооддоо шахагдан нүүдэллэж буй хүмүүс, дүрвэгсэд болон орогнол хүсэгчид зэрэг нийгмийн гадна орхигдож байгаа олон түмэн боломжгүй сөрөг үр дагаврыг өөрт үүрч байдаг бөгөөд хүн худалдаалахын эсрэг арга хэмжээ тэдгээрийн ашиг тусыг хүртэх ёстой тэр хүмүүсийн заримын нь хувьд тийм ч сайн үр дүн авчрахгүй байна.

Энэхүү илтгэлийг бэлтгэхэд ашигласан арга

Эмэгтэйчүүдийг худалдаалахын эсрэг дэлхий нийтийн Холбоо (GAATW)-ноос тус тусдаа орнуудын талаарх энэхүү түүвэр бичвэрийн найман бүлгийг бэлтгэх захиалгыг есөн өөр мэргэжилтэнд өгсөн юм. Холбогдох орны хүн худалдаалахтай холбоотой хууль тогтоомж, түүнчлэн худалдаалагдсан буюу худалдаалагдаж болох хүмүүст үйлчилдэг бусад (цагаачлал, ажил эрхлэлт, нэн ялангуяа бэлгийн үйл зэрэгт холбогдох) хууль тогтоомжийн тойм судалгаа хийхийг тэднээс хүссэн. Мөн эдгээр хууль тогтоомжийн үзүүлэх нөлөөний талаарх мэдээлэл агуулсан байж болох буюу эцэс сүүлд нь цагдаагийн гарт орсон буюу төр, засгийн, эсхүл төрийн бус байгууллагын хоргодох байранд орогнож байгаа худалдаалагдсан хүмүүст юу тохиолдсоныг харуулсан аливаа нийтлэлийн тоймыг бэлтгэхийг тэднээс хүссэн юм. Цөөн хэдэн тохиолдолд (Австрали болон Бразил гэх мэтийн улсад) үүнийг зохиогч нар төрийн албаны хүмүүс болон худалдаалагдсан хүмүүст туслалцаа үзүүлэх үүрэгтэй бусад хүмүүстэй уулзаж ярилцсан юм. Гэхдээ хүн худалдаалахын эсрэг санал санаачилгын үр нөлөөг өөрт амсаж мэдэрсэн хувь хүмүүстэй уулзаж, ярилцага хийх хүсэлтийг тэдэнд тавиагүй.

Аз болоход бусад судлаачдаас тодорхой бүлгийн хүмүүстэй ярилцаж, хүн худалдаалахын эсрэг арга хэмжээ тэдэнд ямар нөлөө үзүүлсэн талаар олж мэдсэн зүйл хэвлэлд нэгэнт гарсан байлаа. Жишээ нь, 2002 оны эхээр Баруун Африкийн нэгэн оронд (Мали) судлаачид хөрш зэргэлдээ Кот д'Ивуарт хүүхэд аваачиж худалдахын эсрэг засгийн газраас хоёр жилийн өмнө авч хэрэгжүүлсэн арга хэмжээ мали хүүхдүүдэд тун олон сөрөг нөлөөтэй байсан талаар НҮБ-ын хүүхдийн байгууллага болох ЮНИСЕФ-д хэлсэн байдаг (Кастл ба Диарра, 2002). Тосгоны түвшинд хүүхэд худалдаалах явдлаас сэргийлэх “Сэрэмжийн хороо”-ноос бүх залуусыг ямарч нөхцлөөр тосгоноо орхиж явахыг зогсоох талаар хийж байгаа оролдлого нутаг орондоо чөлөөтэй зорчих тэдний эрхийг хэрхэн зөрчиж буйг зохиогчид тайлбарласан байна. Эдгээр болон ижил төрлийн бусад дүгнэлтийг GAATW-ын мэргэжилтнүүд хүн худалдаалахын эсрэг арга хэмжээ хүний эрхэд хэр нөлөө үзүүлж байгааг шалгах явцдаа хийжээ.

Найман бүлгийг зохиогчид өөрсдөө хүн худалдаалахын эсрэг буюу түүнтэй холбоотой хүний эрхийн төлөө ажилд гаршсан, ихээхэн туршлагатай хүмүүс билээ. Тэдний хийсэн эхний дүгнэлтүүдийг бусад бүлгийг бичсэн хүмүүс нэгэн адил тоймлон авч үзсэн байна.

Тодорхой орны байдлыг тодорхойлсон бүлэг тус бүр бүтцийн хувьд ижил байгаа юм. Тэд эхлээд тухайн оронд “хүн худалдаалах” гэдэг юунаас бүрдэж байдгийг авч үзнэ. 2 дугаар бүлэгт хүн худалдаалах явдлын бүхий л талд (хүн худалдаалах явдлаас сэргийлэх, сэжиг бүхий хүний наймаачдыг мөрдөн шалгах, хохирогчдыг хамгаалах, тэдэнд туслалцаа үзүүлэх) холбогдох өнөөгийн хууль, эрхзүйн хүрээг тодорхойлж байна. Олонхи оронд төр засгийн болон ТББ-уудын хүчин чармайлт эмэгтэйчүүд, охидыг хүчээр биеэ үнэлүүлэх явдлыг оролцуулаад хүн худалдаалах хэрэгт голлон чиглэж байна. Гэхдээ энэхүү түүвэр бичвэрийн хүрээ хүчээр биеийг нь үнэлүүлэх явдлаар хязгаарлагдахгүй, эрэгтэйчүүд, хөвгүүдийг татан оролцуулж байгаа мөлжлөгийн чанартай бусад хэлбэрийн хүний наймааг ч нэгэн адил авч үзэж байгаа болно.

3 дугаар бүлэгт тухайн орны тодорхой хууль тогтоомж болон бодлогыг гол болгон авч үзэж, эдгээр нь хэр зохистой, хэрхэн хэрэглэх болон хэрэгжүүлэх вэ гэдэгт анхаарлаа хандуулсан болно. 4 дүгээр бүлэгт цагаачлан ирэгсэд болон гадагш цагаачлагчдыг тойрсон хууль тогтоомж, бодлого болон практик үйл ажиллагаа, мөн шилжин суурьшигч ажилчдыг мөлжих, тэдэнтэй зүй бус харьцахаас сэргийлэх хүчин чармайлтыг авч үзэж, хүн худалдаалах хэрэгт нөлөө бүхий, хүний наймааг ямар нэг хэмжээгээр хааж байгаа буюу худалдаалагдсан хувь хүмүүст үйлчилж байгаа (тухайлбал, тэднийг эх нутагт нь түргэн буцаах) арга хэмжээнүүдийг голлон авч үзсэн болно.

5 дугаар бүлэгт эдгээр хууль тогтоомж болон бодлого хохирогч этгээдүүдийн хүний эрхэд хэр нөлөөлж байгаа талаар авч үзсэн болно. Мөн энд шилжин суурьшигч ажилчдад ерөнхийдөө (шилжин суурьшихын өмнө болон дараа нь) ямар нөлөөтэй байгаа болон нэн ялангуяа шилжин суурьшсан биеэ үнэлэгч болон дотроо хөдөлгөөнгүй байгаа биеэ үнэлэгчдэд яаж үйлчилж байгааг авч үзсэн. Мэдээлэл олсон алив тохиолдолд шилжин суурьшигч хүүхдүүдэд хэрхэн нөлөөлж байгаа байдлыг мөн авч үзсэн. Хүн худалдаалахын эсрэг бодлого барьсны ач тус сөрөг үр дагавраасаа илүү юү, дутуу юү гэдгийг үнэлж дүгнэхийг бид чармайгаагүй болно. Ямар ч тохиолдолд бидний гаргасан хүчин чармайлт сөрөг үр дагавартай байх ёсгүй, эдгээр хүмүүс хүн худалдаалахын эсрэг хүчин чармайлтын дагалт бүтээгдэхүүн бус харин засгийн газар болон бусад оролцогч хэсгийг үл хайхарсны уршиг юм гэдгийг гаргаж тавихад байгаа юм.

Юутай ч гэсэн төгсгөлийн 6 дугаар бүлэгт энд тодорхойлон дурдсан хүн худалдаалахын эсрэг арга хэмжээний сөрөг буюу үр нөлөө багатай талыг нь засч залруулах арга хэмжээг санал болгож байгаа юм.

“Хүн худалдаалах” гэсэн нэр томъёоны тодорхойлолт

2000 оны 11 дүгээр сард НҮБ-ын Ерөнхий Ассамблей гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр *Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг Конвенци*, мөн шан харамж авах замаар хүмүүсийг хууль бусаар хил давуулахад туслах ажиллагаатай холбоотой нэг нь хүн худалдаалах, нөгөө нь хүн хил зувчуулах асуудлаарх хоёр нэмэлт протокол баталсан билээ. Ялангуяа аж үйлдвэржсэн орнууд хуурамч баримт бичигтэйгээр цагаачлах буюу хилийн байцаан өнгөрүүлэх цэгээр бус улс орондоо нэвтэрч буйгаас гадна хууль ёсоор орж ирсэн ч визийн хугацаагаа хэтрүүлэх буюу ажил эрхлэх зөвшөөрөлгүйгээр ажил олж хийж байгаа хүмүүст санаа зовохоосоо илүүтэй хууль бусаар шилжин суурьших асуудалд ихэд санаа зовох болсон цаг үед эдгээрийг батлан гаргасан юм.

Энэхүү түүвэр бичвэрт *Хүн, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг худалдаалах явдлаас сэргийлэх, таслан зогсоох болон шийтгэх тухай Протоколыг* НҮБ-ын Хүн худалдаалах асуудлаарх Протокол гэж байгаа ч заримдаа үүнийг 2000 оны сүүлчээр анхлан гарын үсэг зурсан газрын нь нэрээр *“Палермогийн Протокол”* гэдэг. Үүнийг “олон улсын эрхзүйд хүн худалдаалах явдлын хамгийн анхны тод томруун тодорхойлолт” гэж үздэг (Weissbrodt and Anti-Slavery International, 2002, 18) бөгөөд энэ протокол 2003 оны 12 дугаар сард хүчин төгөлдөр болсон юм.

Хүн худалдаалах асуудлаарх Протоколын 3 дугаар зүйлд хүний наймааг дараах байдлаар тодорхойлжээ.³ Үүнд:

- (а) “Хүн худалдаалах гэж мөлжих зорилгоор айлган сүрдүүлэх, хүч хэрэглэх буюу албадах, хууран мэхлэх, төөрөгдүүлэх, эрх мэдэл буюу албан тушаалаа урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах буюу бусдыг хяналтдаа байлгадаг хүмүүсээр зөвшөөрүүлэх үүднээс шан харамж, мөнгө өгөх/авах буюу тэдний туслалцааг авах замаар хүмүүсийг элсүүлэх, зөөх, цааш дамжуулах, орогнуулах буюу хүлээн авахыг хэлнэ. Мөлжлөг гэдэгт хамгийн наад зах нь биеийг нь

үнэлүүлэх буюу бэлгийн мөлжлөгийн бусад хэлбэр, албадан ажиллуулах буюу үйлчлүүлэх, зарцлах буюу түүнтэй ижил төрлийн үйл ажиллагаа явуулах, боолчлох буюу эд эрхтэнийг нь авах зэргээр бусдыг мөлжих явдлыг хэлнэ”.

- (b) Энэхүү зүйлийн (a) дэд хэсэгт дурдсан мөлжих санаархлаар аливаа арга хэрэгсэл ашигласан нөхцөлд хүн худалдаалах хэргийн хохирогсад тус дэд хэсэгт дурдсан санаатай мөлжлөгийг зөвшөөрсөн байх нь ач холбогдолгүй.
- (c) Мөлжих зорилгоор элсүүлсэн, зөөвөрлөсөн, цааш дамжуулсан буюу орогнуулсан хүүхдийг энэхүү зүйлийн а) дэд хэсэгт дурдсан аливаа арга хэрэгсэл ашиглаагүй ч “худалдагдсан хүн” гэж үзнэ.
- (d) “Хүүхэд” гэж 18 насанд хүрээгүй аливаа хүнийг хэлнэ.

Тус тодорхойлолтод өөр хоорондоо ялгаатай гурван элемент хамаарна.

1. Хэн нэгнийг элсүүлэх буюу аваачих (“элсүүлэх, зөөвөрлөх, дамжуулах г.м.”) үйлдлүүд
2. Энэхүү үйлдлийг хийж байгаа арга хэрэгсэл (“айлган сүрдүүлэх, хүч хэрэглэх буюу бусад хэлбэрээр албадах, хууран мэхлэх, төөрөгдүүлэх, эрх мэдэл буюу албан тушаалаа урвуулан ашиглах г.м.”)
3. Мөлжлөгийн хэлбэр гэж үзэж болох байдлаар хүмүүсийг элсүүлэх буюу авч явах зорилго

18 ба түүнээс дээш насны хүмүүсийн хувьд хүн худалдаалах хэргийн бүрдэлд дээрх гурван элемент орсон байх ёстой. Гэхдээ 18 нас хүрээгүй өсвөр насныхан болон хүүхдүүдийн хувьд өмнөх 2 дугаар заалтад буй арга хэрэгсэл ашиглаагүй ч байж болох бөгөөд мөлжих зорилгоор айлган сүрдүүлэх буюу хууран мэхлэхгүйгээр 18 насанд хүрээгүй өсвөр насныхныг элсүүлсэн байх л хангалттай.

Ихэнх уншигчдын хувьд энэхүү тодорхойлолтыг ойлгоход амаргүй. Янз янзын өөр ашиг сонирхолтой засгийн байгууллагын төлөөлөгчдийн хоорондын удаан хугацааны маргаан мэтгэлцээний үр дүнд ийм үг хэллэг гарч ирсэн нь мэдээж юм. Гэхдээ энэхүү тайлбар ээдрээтэй байгаа учраас уг үг хэллэгийг үндэсний хууль тогтоомждоо авч хэрэглэх, хууль сахиулах албаны хүмүүст

илрүүлэх, урьдчилан сэргийлэх ёстой гэмт хэргийн нь бодит тодорхойлолт байдлаар хүргэх үед бэрхшээл үүсгэж байсан. Ихэнх нөхцөл байдалд энэ нь хууль сахиулах буюу цагаачлалын алба мэтийн бусад байгууллагын ажилтнуудын хувьд үйл ажиллагаандаа баримтлах тодорхойлолт болж сайн чадахгүй байгаа юм. Үүний улмаас тэд хууль хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа янз бүрийн тайлбар сэлтийг хайх буюу уг тайлбарыг буруу ашиглах, буруу тайлбарлахад хүрч байна.

Хүмүүсийг элсүүлж байгаа “зорилго” гэдэг нь хүний наймааны тодорхойлолтын амин хэсэг болох учраас албадан ажиллуулах буюу боолчлох маягийн олон нөхцөл байдалд хүргэж байгаа цаад учрыг олох шаардлагатайг тэмдэглэвэл зохино. Үүнд мөн “биеийг нь үнэлүүлж мөлжих буюу бэлгийн мөлжлөгийн бусад хэлбэр” багтаж байгаа юм. “Бэлгийн мөлжлөг” гэсэн нэр томъёог олон улсын хэмжээнд тайлбарлан тодорхойлсон зүйл үгүй учраас улс орнууд өөр өөрийнхөөрөө тодорхойлж, асуудлыг ихэвчлэн зөнд нь орхих явдал олонтаа байна. “Бусдын биеийг үнэлүүлж мөлжих” гэсэн нэр томъёог хүн худалдаалахыг хориглох Конвенци гэгддэг *Хүн худалдаалах болон бусдын биеийг үнэлүүлж мөлжих явдлыг хориглох тухай НҮБ-ын Конвенцид* (1949) тодорхойлж, олон улсын эрхзүйд оруулж ирсэн байна. Энэхүү Конвенци нь гуравдагч этгээд “бусад хүн зөвшөөрсөн байлаа ч түүний биеийг үнэлүүлж мөлжих” (1.2 дугаар зүйл)⁴ хэрэгт хамааралтай юм. Энэ нь хэн нэгний биеэ худалдаж олсон орлогоос ашиг хүртэнэ гэсэн үг юм. “Биеийг нь үнэлүүлж мөлжих” гэдэг нь хүчээр янхандуулахаас ч нэн өргөн утгатай. Гэхдээ 2000 онд батлагдсан НҮБ-ын Хүн худалдаалахын эсрэг Конвенцид дурдсанаар насанд хүрэгчдийг элсүүлсэн нөхцөлд “хүн худалдаалах” гэсэн нэр томъёонд гуравдагч этгээд бэлгийн ажил эрхлэгчээс мөнгө авах бүх тохиолдлоос гадна өмнөх 2 дахь заалтын дагуу тэр эмэгтэй буюу эрэгтэйгээс өөр хэн нэгэн хүнд арилжааны журмаар бэлгийн ажил хийж мөнгө олж өгөх аль нэг хэлбэрийн албадлагад хэдүйнээ өртсөн тохиолдол хамаарна.⁵

НҮБ-ын Хүн худалдаалах асуудлаарх Протоколд орсон нэр томъёонуудын учир холбогдлын талаарх албан ёсны тайлбарт “энэхүү Протокол нь зөвхөн хүн худалдаалсан нөхцөлд бусдын биеийг үнэлүүлж мөлжих болон бусад төрлийн бэлгийн мөлжлөгийг авч шийдвэрлэнэ. “Бусдын биеийг үнэлүүлж мөлжих” буюу “бусад хэлбэрийн бэлгийн мөлжлөг” гэсэн нэр томъёог

Протоколд тодорхой тайлбарлаагүй учраас энэ нь оролцогч Талууд өөр өөрсдийн дотоодын хууль тогтоомжоор биеэ үнэлэх асуудлыг хэрхэн шийдвэрлэх тал дээр хохирол учруулахгүй”.⁶ Ялгаатай нь, Хүн худалдаалахыг хориглох тухай өмнөх Конвенци биеэ үнэлэх явдлыг илтэд буруушааж, удиртгал хэсэгтээ “биеэ үнэлэх явдал болон түүнийг дагалдсан биеийг нь үнэлүүлэх зорилгоор хүн худалдаалах гэмт үйлдэл нь хүний эрхэм чанар, эрхэмсэг байдалд харш зүйл” хэмээн нотлон бичсэн байдаг. Үүний улмаас бэлгийн ажил эрхлэгч олон хүн болоод тэднийг төлөөлсөн байгууллагууд Хүн худалдаалахыг хориглох Конвенцийг өөдтэй биш зүйл гэж үздэг. Эмэгтэйчүүдийг худалдаалахын эсрэг дэлхий нийтийн холбоог оролцуулаад эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалагч олон байгууллага яг ийм байдлаар хандаж, эмэгтэйчүүд өөрсдийн ажил амьдралаа сонгохдоо мэдээлэл бүхий шийдвэр гаргах эрхтэй гэгцгээж байна. Гэхдээ бусад нь болохоор засгийн газрууд эмэгтэйчүүд (эрэгтэйчүүд)-ийн бэлгийн зан үйлийг хянах, арилжааны шинжтэй бэлгийн амьдралыг хориглох буюу үүнд мөнгө төлж байгаа хүмүүсийг шийтгэх эрхтэй, тийм ч үүрэгтэй гэж мэтгэж байна.

Дэлхий даяар амьдарч байгаа бэлгийн ажил эрхлэгчдэд учирч байгаа хор хөнөөл НҮБ-ын Конвенцид дурдсанаас ч хол давуу юм. Энэ бол нийгмийн хэм хэмжээ, зан суртахууны асуудалтай нягт холбоотой. Үүнээс улбаалаад шашин болоод үзэл суртал мөн чухал үүрэгтэй бөгөөд бусдад нийгмийн хэм хэмжээг тулган хүлээлгэх (хүмүүсийн хүний эрхээ эдлэх явдлыг нэн тэргүүнээ дээдлэн дэмжихийн оронд) хүсэлтэй консерватив засгийн газрууд бэлгийн ажил эрхлэгчдийг бусад бүлгийн хүмүүсийг бодвол хүний эрхээ эдлэх эрхзүйн чадвар багатай гэж ялгаварлан дарамталдаг хүчирхэг хэрэглүүр байсаар ирэв.

“Хүн худалдаалахын эсрэг арга хэмжээ” юунаас бүрддэг вэ?

Хүний наймаа гэдэг нийгэм, эдийн засаг, гэмт хэрэг болон бусад талаас нь харвал өргөн цар хүрээтэй асуудал бөгөөд жендер, эрүүл мэнд, шилжин суурьшилт, хөгжил болон эдийн засаг (ялангуяа далд эдийн засаг) зэрэг асуудалтай холбоотой. Тал бүрээс нь харахад хүний наймаатай шийдвэртэй тэмцэх, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний амжилт ололтыг үнэлэх янз бүрийн шалгуурыг нэвтрүүлэх хэрэгтэй гэсэн бодол төрж байгаа юм (UNICEF and Terre des Hommes, 2006, 15). Жишээ нь, 1997 онд GAATW-тэй ойр дотно ажиллаж байсан хоёр мэргэжилтэн тэр үед хүмүүсийг худалдаалах явдлыг

зогсоох төрөл бүрийн стратегийг илтэд тулж дэмжсэн нэлээд хэдэн арга хандлагыг тодорхойлсон бөгөөд эдгээрийгээ “хүний эрхийг дээдлэх хандлага”, “хууль, журам сахиулах хандлага”, “шилжин суурьшилтад хандах хандлага”, “зан суртахууны хандлага”, “хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хандлага” хэмээн нэрлэсэн байдаг (Wijers and Lap-Chew, 1999, 190-209).

Эхлээд НҮБ-ын нийгэм, эдийн засаг буюу хүний эрхийн асуудал эрхэлсэн хороодоос өмнө үндэстэн дамнасан гэмт хэргийн асуудал хариуцсан байгууллагуудаар хэлэлцүүлсэн хүн худалдаалах асуудлаарх НҮБ-ын протокол улс орнуудын зүгээс хүн худалдаалахын эсрэг хууль тогтоомж батлан гаргаж, түүнийг сахин хэрэгжүүлүүлэх явдлыг хөхиүлэн дэмжихэд голлон анхаарсан байна. Энд хүн худалдаалахын эсрэг тэдний авч хэрэгжүүлж болох хэд хэдэн арга хэмжээг тодорхой дурджээ. Өргөн хэмжээнд авч үзвэл эдгээрийг гурван ангилалд хувааж болно. Үүнд:

1. Хүн наймаалагчдыг олж илрүүлэх, мөрдөн шалгах болон яллан шийтгэх хууль сахиулалтын арга хэмжээ
2. Уугуул нутагт нь хүн худалдаалах явдлыг багасгах урьдчилан сэргийлэх арга хэмжээ
3. Худалдагдсан хүмүүст төрөл бүрийн хэлбэрийн туслалцаа үзүүлэх чиглэлийн хамгаалалтын арга хэмжээ

Хууль сахиулахтай холбоотой эхний ангиллын арга хэмжээг Протоколыг соёрхон баталж байгаа улс заавал хэрэгжүүлэх учиртай. Гэхдээ худалдагдсан хүмүүст хамгаалалт үзүүлэх, тэдний хүний эрхийг тулж дэмжихэд хүрвэл энэ нь хэтэрхий сул тул “Хүний худалдаанд өртөж хохирогсдыг хамгаалах”-тай холбоотой 2 дугаар бүлэгт “*зохих тохиолдолд болон дотоодын хууль тогтоомжийн дагуу боломжийн хэмжээнд*” (оролцогч орон бүр худалдаалагдаж хохирогсдын нууц болон нэр усыг чандлан хамгаална, 6.1 дүгээр зүйл), мөн “Оролцогч орон бүр авч хэрэгжүүлэх арга хэмжээг авч үзнэ” (хүний худалдаанд өртөж хохирогсдын бие, сэтгэл санаа болон нийгмийн хохирлыг арилгах талаар, 6.3 дугаар зүйл) гэсэн хэд хэдэн заалтыг нэмж оруулах шаардлагатай. Үнэндээ 6 дугаар зүйлд тусгагдсан туслалцаа үзүүлэхтэй холбоотой, худалдагдсан хувь хүмүүсийн эрхэд хамаарахаас бусад бүх заалтыг соёрхон баталж буй улсууд өөрийн үзэмжээр хэрэгжүүлж болох юм.

Улс гүрнүүд хүн худалдаалахын эсрэг санал санаачилгадаа хүндэтгэн мөрдвөл зохих хүний эрхийн стандарт

Хүний эрх нь зөрчигдсөн (худалдаалагдсан хүмүүс мэтийн) болон өөр бусад тодорхой бүлгийн хүмүүсийн эдлэх ёстой эрхийг баталгаажуулсан олон улсын эрхзүйн үлэмж чухал цогц заалт байдаг. НҮБ-ын гэрээ-хяналтын байгууллагуудаас гаргасан олон тооны баримт бичиг болон зөвлөмж худалдаалагдсан хүмүүс буюу хүн худалдаалахын эсрэг арга хэмжээ сөрөг нөлөө үзүүлсэн хүмүүст шууд хамаарч байна. Гол гол баримт бичгийн жагсаалтыг Хавсралт 3-т үзүүлсэн бөгөөд эндээс судалгаанд хамрагдсан найман орон алийг нь соёрхон баталсан буюу гарын үсэг зурсныг харж болно.

GAATW олон улсын хэмжээнд өнөөдөр хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг гол болгон хүн худалдаалахын эсрэг үйл ажиллагаа явуулдаг хүмүүст зориулан 1996 оноос хойшхи хүчин чармайлтад үндэслэсэн хүний эрхийн талаарх сургалт зохион байгуулсан байна. 1997 онд тус байгууллагаас эрхлэн *Эмэгтэйчүүдийг худалдаалж буй нөхцөлд хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа* нэртэй гарын авлага хэвлэн гаргав. Мөн тус байгууллагаас 1999 онд Бангкокт төвтэй Эмэгтэйчүүдийн сан, Вашингтонд төвтэй Олон улсын Хүний эрхийн хуульчдын бүлэг (одоо глобал эрх нэртэй болсон) гэсэн хоёр ТББ-тай хамтран Худалдаалагдсан хүмүүстэй харьцах хүний эрхийн цогц стандартыг боловсруулж гаргасан байна.⁷ 2001 онд уг гарын авлагыг дахин хянаж, хүний эрхийн стандартыг оруулан *Хүний эрх ба Хүн худалдаалах хэрэг* нэртэй *Гарын авлагыг* дахин хэвлэж гаргасан. ТББ-ууд наад захын стандартыг боловсруулахдаа одоо үйлчилж байгаа олон улсын эрхзүйн зарчмыг үндэс болгосон бөгөөд Хүн худалдаалах асуудлаарх НҮБ-ын шинэ Конвенцид худалдаалагдсан хүмүүсийн олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхийг дэмжин тэтгэх заалт хангалттай тусгагдаагүйгээс засгийн газруудаас хүн худалдаалахын эсрэг гаргаж буй хүчин чармайлтынхаа төвд худалдаалагдсан хүмүүсийн хүний эрхийг тавихад нь дэмжлэг болж чадаагүй гэж 2000 оноос хойш үзсээр ирсэн хүмүүст барих тулгуур нь болж өгсөн юм.

2000 оноос хойш засгийн газар хоорондын байгууллагуудаас эрхлэн эдгээр эрх гэж юу болохыг тодорхой болгох, засгийн газруудын бодлого, түүнчлэн төрийн бус үйл ажиллагааны секторын практик үйл ажиллагаанд нөлөөлөх

үүднээс хэд хэдэн удирдамж боловсруулж гаргасан билээ. 2002 онд анхлан гаргасан удирдамжид НҮБ-ын Хүний эрхийн Дээд комиссарын *Хүний эрх болон хүн худалдаалах хэргийн талаар Зөвлөмж болгосон зарчмууд болон Удирдамжийг* иш үндэс болгожээ. Хүн худалдаалахын эсрэг арга хэмжээ нь “хүмүүсийн хүний эрх болон эрхэм чанар, нэн ялангуяа худалдаалагдсан хүмүүсийн эрхийг ноцтойгоор хөндөх ёсгүй...” хэмээсэн Дээд комиссарын 3 дугаар Зарчим нь эмч нар болон эрүүл мэндийн салбарын бусад мэргэжилтнүүд эмчилж буй хүмүүстээ “хохирол” учруулахгүй байх ёстой гэсэн шаардлагатай санаа нэг буй болно. Удирдамж 3-т энэ талаар илүү нарийвчлан оруулж, засгийн газрууд, засгийн газар хоорондын байгууллагууд болон төрийн бус байгууллагуудад “хүн худалдаалахын эсрэг хууль тогтоомж, бодлого ба түүнийг хэрэглэх болон тэдгээрийн үзүүлэх бодит нөлөө хоорондоо ямар холбоотой байгаа” гэдэг дээр хяналт тавих, үнэлгээ дүгнэлт өгөх, мөн “хүн худалдаалахыг багасгаж байгаа өнөөгийн арга хэмжээ болон ийм асуудал нэг газар буюу бүлгээс нөгөөд шилжихэд нөлөөлж байж магад арга хэмжээнүүд хоорондын” ялгааг зааглан тогтоохыг засгийн газар, засгийн газар хоорондын байгууллага болон ТББ-даас хүссэн заалт байгаа юм.⁸ НҮБ-ын Дээд комиссарын энэхүү удирдамжийг засгийн газрын олон байгууллага болон хүн худалдаалахын эсрэг үйл ажиллагаанд оролцож байгаа төрийн бус олон байгууллага олигтой анхаарч үзээгүй.

НҮБ-ын Дээд комиссарын 17 зарчмын 5 нь нэгэнт худалдаалагдсан хүмүүст хамгаалалт үзүүлэх явдалд хамаарна. Бусад зарчим нь хүн худалдаалахаас сэргийлэх, хүн худалдаалахад хамаарах үйлдлийг эрүүгийн хэргээр зүйлчлэх, яллан шийтгэх болон хохирлыг арилгахад хамаарч байна. НҮБ-ын Дээд Комиссарын 11 удирдамж нь Зарчмуудаасаа илүү дэлгэрэнгүй бөгөөд, жишээ нь, “хүний наймаачид болон уг хэрэгтэй холбоотой хүмүүсийн зүгээс худалдаалагдсан хүмүүст хохирол учруулах, тэднийг айлган сүрдүүлэх болон заналхийлэхээс үр дүнтэй хамгаалах” явдлыг хангахыг улс орнууд (засгийн газар хоорондын болон төрийн бус байгууллагууд)-ад зөвлөмж болгосон байна (Удирдамж 6.6).

НҮБ-ын Дээд Комиссарын Зарчмууд нь хүүхдүүд өртсөн тохиолдолд тэдний дээд эрх ашгийг “ямагт нэн тэргүүнээ тавих ёстой”-г нотолсон юм (Зарчим 10). Хойтон жил (2003) нь ЮНИСЕФ худалдаалагдсан хэмээн сэжиглэгдэж буй 18 насанд хүрээгүй аливаа хүнийг хэрхэн хамгаалах, тэдэнд ямар

туслалцаа үзүүлэх ёстой талаар өөрийн гэсэн удирдамжийг баталсан. *Худалдаалагдаж хохирсон Хүүхдийн эрхийг хамгаалах Удирдамж*⁹–д худалдаалагдсан хүүхдүүдэд хамаатай 11 тодорхой асуудал, түүний дотор худалдаалагдсан хүүхэд бүрт харуул хамгаалалт гаргаж өгөх, хэрэг тус бүр дээр үнэлгээ дүгнэлт гаргах болон хүүхдийн дээд эрх ашиг (best interests)-т нийцсэн хамгийн зохистой шийдлийг олж тодорхойлох асуудал багтаж байгаа юм.

Засгийн газар хоорондын бусад байгууллагууд ч үүнийг дагалдав. 2006 онд НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн байгууллага, НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн Дээд Комиссарын газар (UNHCR)-аас хувь нэмрээ оруулж, *Олон улсын Хамгаалалт үзүүлэх тухай Удирдамж: Дүрвэгсэдийн эрхийн байдлын талаарх 1951 оны Конвенцийн 1A(2) дугаар зүйл болон/буюу 1967 оны Протоколыг худалдаалагдаж хохирсон болон худалдаалагдах эрсдэл бүхий хүмүүст хэрэглэх нь нэртэй заавар удирдамжийг батлан гаргасан.*¹⁰ Эдгээр удирдамжид худалдаалагдсан (буюу худалдаалагдсан байж болох) зарим хүмүүс мөрдөн мөшгилтөд өртөх үндэслэлтэй айдас хүйдэс дунд явдаг учраас “тэд дүрвэгсдэд үзүүлдэг олон улсын хамгаалалт эдлэх эрхтэй” гэжээ (параграф 12). Эдгээр удирдамж “худалдаалагдаж хохирогсод болон худалдаалагдан хохирч болох хүмүүсийн орогнол хүссэн өргөдлийг авч үзэх... хор хохирлоос айж эмээх нь хүн худалдаалах явдлын үр дүн үү, аль эсхүл өмнөх үйлдэл нь хэрэг тус бүрийг мөрдөн мөшгихөд хүртэж байна уу гэдгийг нарийвчлан тогтоох” заавар удирдамжийг засгийн газруудад үнэндээ өгсөн юм (параграф 15). UNHCR-ээс гаргасан эдгээр удирдамжид хатуу ширүүн харьцах болон хүнд мөлжлөгийн олон хэлбэрийг жагсаан оруулж, эдгээр нь “мөрдөн шалгахад үндсэндээ хүргэх” (*ibid.*) ба улмаар хамгаалалт шаардлагатай байгаа хувь хүмүүсийг дүрвэгсэд адил үзэх ёстой гэжээ,

Хүн худалдаалах асуудлаарх НҮБ-ын Протокол батлагдсаны дараа НҮБ-ын янз бүрийн байгууллага худалдагдсанд тооцогдож байгаа хүмүүсийн эрхийг голлон анхаарсан хэд хэдэн нэмэлт удирдамж гаргасан нь эргэлзээгүй чухал ач холбогдолтой байлаа. Үнэндээ бүх тохиолдолд эдгээр шинэ стандартад өнөөдөр мөрдөж байгаа олон улсын эрх зүйг иш үндэс болгосон байна. Хамтад нь авч үзэх юм бол эдгээр стандарт олон улсын “эрхзүйн зөөлөн” стандартын үлэмж шинэ цогцсыг бүрдүүлж байгаа юм. Хэдийгээр улс орнууд эдгээр шинэ стандартыг удирдлага болгох тодорхой үүрэг амлалт аваагүй ч

олон тохиолдолд тэд шинэ стандартын үндэс суурь болсон олон улсын өнөөгийн баримт бичгүүдийг соёрхон баталсан бөгөөд тэдгээрийг хүндэтгэн дагах хүчин чармайлтдаа хариуцлагатай хандаж чадахаар байна.

Дэлхийн зарим бүс нутагт бүс нутгийн байгууллагууд худалдаалагдсан хүмүүсийн эрхийг тулж дэмжих чиглэлийг эрэлхийлж, НҮБ-ын Хүн худалдаалах асуудлаарх Протоколоос давж гарсан хүн худалдаалахын эсрэг баримт бичгийг мөн батлан гаргасан. Европын Зөвлөлөөс 2005 оны тавдугаар сард баталсан *Хүн худалдаалахын эсрэг үйл ажиллагааны тухай Конвенци* оршил хэсэгтээ “хүн худалдаалахын эсрэг бүхий л үйл ажиллагаа болон санал санаачилгууд нь ялгаварлан гадуурхсан бус, жендерийн тэгш байдал болон хүүхдийн эрхийг хамгаалах хандлагыг харгалзан үзсэн байх ёстой” хэмээжээ. Тус Конвенци хохирсон хүмүүсийн эрхэд онцгой анхаарал хандуулж байгаагаас гадна энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх утгаар “Хүний эрхэд суурилсан хандлагыг дэмжин урагшлуулах болон ... хүн худалдаалахаас сэргийлэх бүхий л бодлого, хөтөлбөрүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх болон үнэлж дүгнэхдээ жендерийн гол гол төлөөлөгчдийг оролцуулах болон хүүхдийн мэдрэмжтэй арга хандлага ашиглах” шаардлагыг уг Конвенцийг соёрхон баталж байгаа улсуудад мөн тавьж байгаа юм (5.3 дугаар зүйл).¹¹

Энэхүү түүвэр бичвэрт тоймлон өгүүлсэн найман орны засгийн газрын одоо явуулж байгаа үйл ажиллагааг харах юм бол тэдгээр засгийн газрын олонхи нь “хүний эрхийн хандлага” буюу “эрхэд суурилсан хандлагыг” хэзээ зөвшөөрч, авч ашиглана гэж өөрсдөө үүрэг хүлээснээ мэдэж байгаа гэдэгт итгэхэд хэцүү юм. Үнэнийг хэлэхэд хүний эрхийн хандлагад худалдаалагдсан буюу худалдаалагдаж болох хүмүүсийг гол болгож, баримталж байгаа стратеги эдгээр хүмүүст ямар нөлөө үзүүлж байна гэдгээр түүнийг үнэлдэг. Энэхүү хандлагад өмнө нь худалдаалагдсан хүмүүсийн талаарх мэдээлэлд гол нь тулгуурлаж, ямар хувь хүмүүс болон бүлгийнхэн бусдаасаа илүүтэй худалдаалагдах магадлалтайг тодорхойлох, тэднийг хэн хариуцан хамгаалж буйд дүн шинжилгээ хийх болон (ямар ч оронд байлаа гэсэн) тэдний хүний эрхийг тулж дэмжих, илүү үр дүнтэй хамгаалахад ямар арга хэмжээ шаардлагатай талаар зөвлөмж гаргах явдал багтана. Энэ нь хойнох найман бүлэгт тодорхойлсон болон бусад аль нэг орны баримталж байгаа стратегид эрс өөрөөр хандахад хүргэж байна.

Бүс нутгийн бусад стандарт болон үйл ажиллагааны хөтөлбөр нь худалдаалагдсан хүмүүсийн эрхийг хүндэтгэхдээ энэхүү арга хандлагыг нэн тэргүүнээ баримтлах тов тодорхой үүргийг засгийн газруудад хүлээлгэж байна. Ерөнхийдөө шилжин суурьшигч ажилчдын эрхийг дэмжин хамгаалах зорилготой НҮБ-ын тодорхой Конвенц (НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1990 онд баталсан бөгөөд 2003 онд хүчин төгөлдөр болсон *Шилжин суурьшигч бүх ажилчид, тэдний гэр бүлийнхний эрхийг хамгаалах тухай Олон улсын Конвенци*) бас байгаа боловч ард иргэд нь эх орноо орхиж шилжин нүүдэллэж байгаа улсууд түүнийг их төлөв соёрхон баталсан бөгөөд олон тооны шилжин ирэгсдийг хүлээн авч байгаа аж үйлдвэржсэн ганц ч орон батламжлаагүй билээ. Энэхүү түүвэр бичвэрт авч үзсэн найман орноос ганц Босни ба Герцогевин энэхүү Конвенцийг соёрхон баталжээ.

Өнөөгийн олон улсын эрхзүйд үндэслэсэн стандартуудын хажуугаар засгийн газар хоорондын байгууллагууд сайн практик үйл ажиллагааны асуудлаар мөн зөвлөмж гаргасан байна. Эдгээр зөвлөмж нь холбогдох төрөлжсөн байгууллагуудын туршлагад үндэслэсэн бөгөөд засгийн газрын болон засгийн газар хоорондын байгууллагууд, ТББ-уудад зориулсан зөвлөгөө хэлбэртэй юм. Жишээ нь, 2004 онд Олон улсын Шилжин сууршигчдын Байгууллага (IOM) худалдаалагдсан хүмүүст үзүүлэх сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаарх хамгийн наад захын цогц стандартыг боловсруулж гаргасан.¹² IOM-ын *Наад захын стандартууд* нь худалдаалагдсан хүмүүсийг аварсан цагаас нь эхлээд сэтгэц засах бүхий л үйл явцын туршид сэтгэцийн эрүүл мэндийн бүх талын, зохицолдоот халамж, үйлчилгээ үзүүлэх боломжоор хангах зорилготой юм. Мөн эдгээр стандарт хүн худалдаалах явдалтай тэмцэх салбарт хөтөлбөр хэрэгжүүлж байгаа олон байгууллагыг удирдлагаар хангах зорилготой. 2007 онд IOM хүн худалдаалахын эсрэг үйл ажиллагаанд оролцсон өмнөх 13 жилд хуримтлуулсан туршлага, авсан сургамжаа нэгтгэн дүгнэсэн *Хүн худалдаалах хэргийн хохирогсдод шууд тусалцаа үзүүлэх тухай IOM-ын Гарын авлагыг* нийтэлж гаргасан.¹³

2003 онд Дэлхийн Эрүүл мэндийн Байгууллага (WHO) *Худалдаалагдсан Эмэгтэйчүүдтэй тулж ярилцахад зориулсан Ёсзүйн болон Аюулгүй ажиллагааны Зөвлөмжийг* цогцоор нийтэлж гаргасан. Энд худалдаалагдсан эмэгтэйчүүдтэй ёсзүйтэй, аюулгүй байдлаар асууж ярилцахад баримтлах 10

гол чиглэл зарчим орсон байна.¹⁴ Эдгээрийн олонхийг худалдаалагдсан охид, хөвгүүд болон тэр ч бүү хэл насанд хүрсэн эрэгтэйчүүдэд мөн хэрэглэж болно.

Энэ бол худалдаалагдсан хүмүүсийн талаарх бодлого буюу хүн худалдаалах явдлыг зогсоон барих арга хэмжээг боловсруулж батлахдаа улс орнууд хүндэтгэн сахих үүрэгтэй олон улсын эрхзүйн хэм хэмжээнд үндэслэсэн стандартын уртаас урт жагсаалт юм. Гэхдээ эдгээрийг тайлбарлан таниулах гэж ихээхэн чармайсан хэдий ч тэдгээрийг дэмжих, эсхүл тэдгээртэй нийцэж байгаа эсэхэд хяналт тавих талаар харьцангуй бага зүйл хийсэн байна. Хэрэг дээрээ олон улсын хамтын нийгэмлэгийн бий болгосон систем нь нэг л ажиллаж өгөхгүй байгаа юм.

Хүн худалдаалахын эсрэг арга хэмжээний хүлээн зөвшөөрч боломгүй харш нөлөөг хязгаарлах зарчмууд

Хүн худалдаалахын эсрэг зарим арга хэмжээ хувь хүний эрх, тухайлбал тэдний чөлөөтэй зорчих эрхийг нь хязгаарласан хамгаалалтын хэлбэрүүдийг агуулж байна. Жишээ нь худалдаалагдсан хүмүүсийг орогнох байр буюу баривчлах төвд байлгахдаа өөрсдийн нь сайн сайхны төлөө юм шигээр аашилдаг буюу өсвөр насныхныг худалдаалагдчихвий гэж эмээсэн дүр үзүүлж, тосгоноос гарч хаа нэгэн газар ажил эрэх хэрэггүй хэмээн зааварчилдаг байна. “Хамгаалалт” болон хүний эрх, эрх чөлөөний хооронд болон ерөнхийдөө хувь хүний эрх болон тодорхой хувь хүмүүс буюу бүлгийнхнийг хамгаалах арга хэмжээнүүдийн хооронд зохих тэнцвэр (balance) бий болгоход НҮБ-ын гэрээ-хяналтын байгууллагуудаас гаргасан тайлбар нэн хэрэгтэй болдог. *Иргэний болон Улстөрийн эрхийн тухай Олон улсын Конвенцийн* дагуу байгуулагдсан гэрээ-хяналтын байгууллага болон Хүний эрхийн хорооноос 1999 онд гаргасан Зорчих эрх чөлөөний тухай Ерөнхий тайлбар 27 нь энэхүү тэнцвэрийг тулж дэмжих ёстой зарчмуудыг тодруулахад тус болж байна. Тус тайлбарт:

Хязгаарлалтын арга хэмжээнүүд нь тэгш зохистой хандах зарчимд (principle of proportionality) нийцэж байх ёстой; тэдгээр нь хамгаалах чиг үүргийг ханган хэрэгжүүлэх зүй зохистой арга хэмжээ байх ёстой; тэдгээр нь хүссэн үр дүнд хүрэх арга хэрэгслүүдийн дотроос эрхийг хамгийн багаар хохироох хэрэгсэл байх ёстой; тэдгээр нь хамгаалах ёстой эрх ашигт нийцэж (proportionate) байх ёстой... Тэгш зохистой хандах зарчмыг

хязгаарлалтын хүрээг тогтоож байгаа хууль тогтоомжид төдийгүй захиргааны болоод шүүх эрх мэдлийн байгууллагууд хуулийг хэрэглэхдээ хүндэтгэн мөрдөх шаардлагатай гэжээ.¹⁵

Дараах бүлгүүдэд тэгш зохистой хандах зарчмыг эсхүл хүндэтгэн мөрдөөгүй, эсхүл төр, засгийн эрх мэдэлтнүүд хүмүүсийг худалдаалагдахаас сэргийлэх, эсхүл худалдаалагдсан хүмүүсийг хамгаалах нэрийн дор хязгаарлалт тавихдаа үүнийг анхаарч үздэггүйг харуулсан тоймгүй олон жишээг иш татсан байгаа. Үүнтэй нэг адилаар, хүн худалдаалах тохиолдолд сонгон авч хэрэглэж болох арга хэмжээг “хамгийн хор хохирол багатай” (the least intrusive) байлгах талаар анхаарал бага хандуулсан нь илт байна. Авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн жишээг эргэн харж, хэт хязгаарлалтын шинжтэй хүн худалдаалахын эсрэг арга хэмжээнүүдэд өөрчлөлт оруулахыг НҮБ-ын гэрээ-хяналтын байгууллагуудын зүгээс тодорхой засгийн газруудад уриалах хүртэл хэдэн жил болж болох биз. Гэхдээ энэ завсар эдгээр үйлдлийг өөрчлөх үйл ажиллагааг үндэсний түвшинд эхлүүлж болохуйцаар эдгээр арга хэмжээг тодорхойлох шаардлагатай.

Хүүхэд болон 18 насанд хүрээгүй залуу хүмүүсийн хувьд эл байдал олон улсын эрхзүйд нэлээд ээдрээ түвэг учруулж байгаа бөгөөд бие махбодын болон сэтгэл санааны хүчирхийллийн бүх хэлбэр, гэмтэл учруулах буюу хатуу ширүүн харьцах (19 дүгээр зүйл), эдийн засгийн мөлжлөг (32 дугаар зүйл), бэлгийн мөлжлөг болон бэлгийн хүчирхийлэл (34 дүгээр зүйл) болон “аливаа зорилго буюу хэлбэрээр хүүхэд хулгайлах, зарах буюу худалдах” (35 дугаар зүйл) зэргийг оролцуулаад маш олон төрлийн хүч түрэмгийлсэн харьцаанаас хүүхдийг хамгаалах арга хэмжээг улс орнууд авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаа юм.¹⁶ Хамгаалалтын олон хэлбэр нь хүүхдүүд Конвенциэр баталгаажсан эрхээ ямар хэмжээнд хэрэгжүүлж чадах тэр чадамжийг нь хязгаарлаж боогдуулж болзошгүй. Конвенци нь өөрөө хүүхдийн талаар авч хэрэгжүүлж байгаа бүхий л үйл ажиллагаанд хүүхдийн “дээд эрх ашгийг” нэн тэргүүнээ харгалзах ёстой (3 дугаар зүйл) ба хүүхэд нас, бүрэн өсөлт бойжилтдоо тохирсон хэмжээгээр өөрийн үзэл бодол болон эрхийг нь хөндөж байгаа алив асуудлын талаар бусдад сонсгох, тэдэнд хүргэж ойлгуулах эрхтэй гэдгийг онцгой анхаарах замаар ийм тэнцвэрт харилцааг яаж буй болгохыг зааж өгч байна (12 дугаар зүйл). Гэхдээ Хүүхдийн эрхийн Хороо (Конвенцийн дагуу байгуулагдсан) засгийн газрууд

өсвөр насныхантай “эрх эдлэгч” гэсэн маягаар харьцах талаар хангалттай зүйл хийхгүй байгаад сэтгэл эмзэглэж байгаагаа илэрхийлсэн явдал чухал юм.¹⁷

Энэхүү түүвэр бичвэрт дурдсан хүүхэд худалдаалах тохиолдолд (Нигерид) засгийн газрын агентлагууд *Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн* 3 ба 12 дугаар зүйлд тодорхойлсон үндсэн зарчмуудыг огт анхаарч үзээгүй нь тодорхой. Өсвөр насныхныг худалдаалагдахаас сэргийлэх хүчин чармайлт залуу хүмүүсийн бусад олон эрхийг тэгш зохистой хандлагын зарчмыг урьтал болгодоггүй хүн худалдаалахын эсрэг арга хэмжээний эрхшээл дор тавьсан юм шиг байна. Урьдчилан сэргийлэх хэд хэдэн хөтөлбөр нь өсвөр насныхныг төрсөн газарт нь барьж байх нь хүүхдүүдэд хичээл сургуулиа үргэлжлүүлэх боломж олгож, (тэгснээр боловсрол эзэмших эрхээ эдлэж байхдаа эдийн засгийн мөлжлөгт үл өртөнө) гэсэн үндэслэлээр зөвтгөж болох зорилт гэсэн ихэрхүү санаан дээр үндэслэж байлаа. Ялгаатай нь, хүүхдийн эрхийн хандлага хэлж буйгаар бол өсвөр насныхны хүний эрхээ эдлэх буюу амьдралаа сайн сайхан болгох чадварыг нь шууд дэмжиж чадахгүй орчинд гэр оронд нь барьж суулгах биш, орон гэрээ орхин явж байгаа тэдний аюулгүй байдлыг нь хангаж өгөхөд нэн тэргүүнээ анхаарах ёстой. Хүүхдийн эрхийн хандлага гэж хүүхдүүдийн боловсрол эзэмших, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдах болон гэр орны хүчирхийллээс хамгаалагдах боломжийг сайжруулах чиглэл барьж ажиллах явдал юм (Доттридж, 2007, 37).

Хүүхдэд онцгой анхаарал хандуулдаг гэрээ-хяналтын байгууллага болох Хүүхдийн эрхийн Хороо шийдвэр гаргагчдын зүгээс гадаад оронд ганцаар байгаа хүүхэд төрсөн орондоо эргэж ирэх ёстой эсэхийг авч шийдвэрлэхдээ харгалзах ёстой хүчин зүйлсийг тодорхойлсон. Энэ бол эх нутгаасаа гадагш худалдаалагдаж, өөр оронд очиж мөлжлөгөд өртөж байгаа ихэнх хүүхдэд тохиолддог нөхцөл байдал юм. “Хэрвээ өөрийн оронд нь хүүхдэд үлэмж хор хохирол учрах бодит эрсдэл байна гэж үзэх гарцаагүй үндэслэл байгаа” бол хүүхдийг эх нутагт нь буцаахгүй байж болно хэмээн тус Хороо тэмдэглэжээ. Тус Хорооны үзэж байгаагаар энэ нь хүүхдийг эх нутагт нь буцаах асуудлыг авч үзэж байгаа орны эрх баригчид тус тусдаа хүүхдүүдийг эх нутагт нь буцаах тохиолдолд эрсдлийг заавал үнэлэх, хүүхдийг эх оронд нь буцаахын өмнө түүнд төрсөн нутагт нь зохих ёсоор халамж үзүүлэх зохицуулалтын арга

хэмжээ авч буй эсэхийг шалгах ёстой. Гэхдээ худалдаалагдсан хүмүүсийн төрсөн нутагт нь хийсэн аливаа шалгалт тэдгээрийн эсрэг хор хохирол буюу бусад асуудал үүсгэж болзошгүй тохиолдолд хоёр орны байгууллагууд шалгалтын ажил нь тухайн залуу хүнд цаашид хор хохирол учруулахгүйгээр хийгдсэн эсэхийг магадлан тогтоох үүрэгтэй.

Ийм төрлийн аюулгүй байдлын үнэлгээ нь худалдаалагдсан насанд хүрэгчдэд ч амин чухал гэж үзэх нь ухаалаг хэрэг байж болно. Насанд хүрэгчдийн хувьд (төрийн албан хаагчид буюу хүний наймаачид зэрэг төрийн бус оролцогчдын зүгээс) нэг ч хүнийг *албадан гаргах* буюу тэдэнд эрүү шүүлт тулгарч болох оронд буцаан хүргүүлэхгүй байх явдлыг хангаж өгөх шаардлагыг *Эрүүдэн шүүхийн эсрэг НҮБ-ын Конвенци* (1984) улс орнуудад тавьдаг. Зарчмын хувьд худалдаалагдсан хүмүүст эрүү шүүлт тулгах эрсдэл байдаг учраас засгийн газрын байгууллагуудын зүгээс худалдаалагдсан хэн нэгэн хүнийг эх нутагт нь буцаахын өмнө эрсдэл болон аюулгүй байдлын үнэлгээг зохих ёсоор хийх явдлыг хэвшүүлэх ёстой. Энэхүү түүвэр бичвэрийн хэд хэдэн бүлэгт тодорхой дурдсанаар практик амьдрал дээр аливаа эрсдэл болон аюулгүй байдлын үнэлгээ хийгдээгүй байхад худалдаалагдсан зарим хүнийг эх нутагт нь буцааж, төрсөн орных нь нисэх буудал, галт тэрэгний буудал буюу боомт дээр аваачаад, эмзэг нөхцөл буюу дахин худалдаалагдах эрсдэлд орхих явдал олонтаа байна. Хуульд худалдаалагдсан хувь хүмүүсийг (увайгүй байдлаар хөөн гаргах биш) хамгаалах ёстой гэдэг нөхцөл тавьж байхад хууль сахиулах болон цагаачлалын албаны хүмүүс хувь хүмүүсийг худалдаалагдсан хүмүүс гэхээсээ өмнө “хууль бусаар цагаачлагчид” хэмээн ангилж өөрсдийгөө зөв гэж үнэмшүүлэхийг байнга оролддог нь бас л тодорхой.

Нутаг орноосоо хол ажиллах үедээ худалдаалагдсан хүмүүс эх орондоо буцаж очмогц ямар эрсдэлтэй тулгарч болох вэ гэсэн асуудал тавигддагаас тухайн хүнд цаашид аливаа хор хохирол учруулахгүй байх талаар хангалттай мэдрэмжтэй арга хэмжээ авч ажиллах ёстой. Олон улс орон үүнийг хэрхэн хийх арга замыг бодож олсон эсэх нь (үнэндээ бараг үгүй биз) одоогоор тодорхойгүй. Хилийн чанадад болон дотооддоо засгийн газрын байгууллагуудаас худалдаалагдсан хүмүүст хэрхэн хандаж байсан байдлаас тэдний өмнө нь авсан сургамж нь тэд гэр орон руугаа явах ажлыг зохион байгуулж, эцэст нь боломжийн төрөл бүрийн аюул эрсдэлтэй тулгарах хэрэг

гарч байсан ч засгийн газрын байгууллагуудтай ямар нэг байдлаар харьцахаас зайлсхийх нь ерөнхийдөө илүү зохимжтой гэсэн дүгнэлт байлаа. Энэ нь л засгийн газрын байгууллагуудаас худалдаалагдсан хүмүүстэй харьцах арга барилыг буруутгасан гол зэмлэл юм.

“Хүний эрхэд үзүүлэх нөлөөг” үнэлэх нь

Учир шалтгаан, үр дагаврын холбоог тогтоох явдал нарийн ухаан шаардах нь ховор. Хүмүүсийн хүний эрхээ эдлэх чадварыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааны нөлөөллийг тодорхой хэмжин үнэлэх аргыг эрэлхийлсэн нэгэн зохиогчийн ажигласнаар:

Нөлөөллийг ойлгоно гэдэг нь үр дүнг тооцох тоон үзүүлэлтүүдийг олох төдийгүй хууль бус буруу харьцааны системийн шинжтэй цаад шалтгааныг аль нэг арга хандлагаар арилгаж буй эсэхийг ойлгохыг хэлнэ. Түр зуурын залруулах хэрэгслээр томоохон тоон үзүүлэлтүүдийг гаргаж болох боловч хэзээ ч эмчилгээ болж чадахгүй. Уг эмчилгээ мэдэгдэхүйц үр дүн хэзээ ч өгч чадахгүй байж болох юм.¹⁹

Худалдаалагдсан хүмүүсийн эрхийг баталгаажуулсан олон улсын нэлээд хэдэн стандарт, түүнчлэн хүн худалдаалахын эсрэг буюу бусад төрлийн арга хэмжээнүүдээр хүний эрхийг үгүйсгэх буюу зүй зохистой бусаар хасч болохгүй хэмээн тунхагласан олон улсын бусад стандарт байгаа бөгөөд хүн худалдаалахын эсрэг арга хэмжээнүүд (буюу холбогдох хууль тогтоомж, бодлого)-ийнхүмүүсийн хүний эрхэд үзүүлэх нөлөөг үнэлэхэд туслах хэд хэдэн техник хэрэгсэл бэлэн байна.

Хөгжлийн төслүүдийн “нийгмийн нөлөөлөл”-ийг үнэлэх зориулалттай зарим техник хэрэгслийг боловсруулаад байна. Олон улсын хүний эрхийн зарим баримт бичиг хөгжлийн зарим санаачилга нутгийн уугуул иргэд буюу үндэсний цөөнх зэрэг тодорхой бүлэг хүмүүст ялгавартай байдлаар нөлөөлөхгүй байх явдлыг хангах шаардлагыг засгийн газруудад тавьж байна.

Хүн худалдаалахын эсрэг арга хэмжээнүүд буюу үүнтэй адил төрлийн засгийн газрын бодлого шийдвэрүүд хувь хүмүүсийн хүний эрхэд хэрхэн нөлөөлөхийг тодорхойлон тогтооход туслах өнөөгийн аливаа хэрэгсэл үгүй байсан үед энэхүү түүвэр бичвэрт авч дурдсан хандлагаар цөөн тооны гол бүлэг хүмүүс, ялангуяа шилжин суурьшигчид, дотооддоо гадуурхагдан нүүдэллэсэн хүмүүс, дүрвэгсэд болон орогнол хүсэгчдэд үзүүлсэн хамгийн

илт нөлөө юу байсныг тайлбарлан харуулах ёстой байсан. Энэхүү түүвэр бичвэрт ихэвчлэн (гэхдээ үргэлж биш) гэр орноосоо алс газар болон өөрийн орноос бусад орнуудад албан бус секторт ажиллаж (эсхүл ажил хайж) байгаа хүмүүст гол анхаарлаа хандуулж байна.

Тиймээс зохиогчид хүн худалдаалахын эсрэг арга хэмжээ шилжин суурьшигч хүмүүст хор хөнөөл учруулдаг буюу тэднийг мөн адил хохироох бусад хүмүүсийн гарт оруулж байгаа жинхэнэ гэмт хэрэгтнүүдэд ямар хохирол амсуулж байгаад нэг их анхаарал хандуулаагүй. Гэхдээ “хүн наймаалагч” гэсэн нэр хаягийг хэт чөлөөтэй хэрэглэж байгаа талаар зарим бүс нутгаас авсан нотлох баримт бий. Жишээ нь, “газрын эзэн” хэмээгддэг хүмүүс нь насанд хүрэгчид болон хүүхдүүдэд хот руу шилжин суурьжиж, ажил олоход нь хэзээнээс тусалдаг байсан Баруун Африкт ийм хүмүүсийг “хүн наймаалагч” хэмээн илчлэн буруутгах нь мөлжлөгийг таслан зогсооход тус болохоосоо илүүтэй тэднээс үйлчлүүлэгчиддээ үзүүлж чадах хамгаалалтыг багасгахад тус дэм болсон нь тодорхой байна. Мөн Бразилд нийгмийн амьдралын олон талыг зохицуулдаг эзэн-үйлчлүүлэгч гэсэн харилцаа энд оролцогч “үйлчлүүлэгчиддээ” хамгаалалт болох нь олонтаа байна. Тиймээс хүн наймаалагчийг олж тодорхойлох нь хүмүүсийн дэлхий даяар бий болгосон бөгөөд одоо цэцэглэж байгаа (хууль ёсоор буюу хууль бусаар) шилжин суурьшихад туслах албан бус механизмыг илчлэхээс илүүтэй нарийн түвэгтэй ажиллагааг шаардаж байна.

Энэхүү түүвэр бичвэрийн зарим бүлэгт хүн худалдаалахын эсрэг арга хэмжээ нөлөө үзүүлсэн ерөнхий чиглэлийг сөхөж, тэдгээр арга хэмжээ худалдаалагдаж байгаа хүмүүсийн тоог цөөрүүлэхэд тус нэмэр болсон эсэхийг үнэлэх оролдлого хийсэн. Зарим нь ганц нэг тохиолдолд анхаарлаа хандуулалгүйгээр өнөөгийн авч хэрэгжүүлж байгаа хүн худалдаалахын эсрэг хууль тогтоомж буюу бодлого, үйл ажиллагааны тодорхой утга оршиж байгаа үнэнхүү онолын шинжтэй чиглэлийг зэрвэс авч үзсэн байна. Өөр бусад нь хувь хүмүүст үзүүлэх нөлөөний талаар чухал хэрэгцээтэй нарийн ширийн зүйлсийг олж мэдэх, хүн худалдаалахын эсрэг арга хэмжээ хэсэг хүмүүсийн хүний эрхээ эдлэх чадварт хэрхэн муу нөлөө үзүүлснийг тухайлан үнэлэх чадвартай байлаа. Мэдээж хэрэг, эдгээр нөлөө ямар байсныг олж мэдэх туйлын үнэ цэнтэй эх сурвалж нь тухайн хүмүүс өөрсдөө байлаа. Хэд хэдэн оронд GAATW-ийн судлаачид худалдаалагдсан хүмүүст үйлчилгээ үзүүлдэг

байгууллагуудтай холбоо тогтоож, хүн худалдаалахын эсрэг арга хэмжээ тэдэнд ямар нөлөө үзүүлсэн талаарх тэдний болон үйлчлүүлэгчдийн нь санаа бодлыг сонсож мэдсэн юм. GAATW-ийн судлаачдын хувьд нэг оронд, тухайлбал худалдаалагдсан хүмүүст (гэрээний үндсэн дээр засгийн газарт) үйлчилгээ үзүүлдэг компани асуултад хариулж чадахгүй хэмээн эрх баригчид нь нотолдог Австралид мэдээллийн энэ суваг хаалттай байсан юм. Энэ тохиолдолд засгийн газар худалдаалагдсан хүмүүсийг хамгаалах зарим хүчин чармайлтаа хаан далдалдаг байсан яг энэ нууцлалыг буруугаар ашиглаж, эдгээр хүчин чармайлтыг ил гаргаж, нарийн судлуулахаас сэргийлдэг байв. Хэрэг дээрээ эдгээр нь хариуцлагаас зайлсхийх арга хэрэгсэл юм.

Улс болгонд хүн худалдаалахын эсрэг арга хэмжээ хор нөлөөтэй байсан хамгийн ил тодорхой бүлэг хүмүүс бол хэдүйнээ худалдаалагдсан болон дараагаар нь тэднийг хамгаалах болон тэнд туслалцаа үзүүлэх (засгийн газрын болон засгийн газрын бус агентлагуудын зүгээс) арга хэмжээ буюу хүний наймаачдыг мөрдөн мөшгих хүчин чармайлтын горыг амссан хүмүүс юм. Гэхдээ “хамгаалах” гэдэг үгийг энд хамаагүй хэрэглэдэг ба худалдаалагдсан хүмүүсийг хамгаалах зарим арга хэмжээ нь хэрэг дээрээ тэднийг тухайн тохиолдол өөр байснаас ч илүүтэй аюулд өртүүлж байна.

Худалдаалагдсан хүмүүсийн энэхүү бүлэгт янз бүрийн хэлбэрээр мөлжих зорилгоор элсүүлсэн насанд хүрэгчид ч, хүүхэд ч багтаж байгаа юм. Тэдний зарим нь үнэхээр мөлжлөг амссан, бусад нь мөлжигдөхөөсөө өмнө баригдсан буюу тусламж эрсэн хүмүүс байдаг. Тиймээс тэдний хамгаалалт эдлэх эрхэд нөлөөлөх хууль тогтоомж болон бодлогыг хэрэгжүүлэх яг анхны алхам нь хүмүүсийн байгаа орны засгийн газраас хэнийг “худалдаалагдсан” гэсэн ангилалд оруулах ёстойг буюу хэн нь хамгаалалт болон тусламж авах эрхтэйг тодорхойлох, үүнд хэрэглэх шалгуур тогтоох явдал юм. Хэдийгээр хэнийг “худалдаалагдсан хүн” гэж үзэх олон улсын стандарт тодорхой мэт боловч олон оронд *de jure* юмуу *de facto* тодорхойлол хэрэглэж байгаа нь зөвхөн албан хүчээр биеийг нь үнэлүүлсэн эмэгтэйчүүд, охидыг “худалдаалагдсан” хэмээн хүлээн зөвшөөрч, бусад замаар мөлжигдөж байсан хүмүүсийг энд оруулж тооцохгүй, хамгаалуулах эрхийг нь хасдаг байна. Хэсэг хугацаанд Нэгдсэн Вант Улсад эдгээр шалгуур өөр бусад газраас илүүтэй хориг шинжтэй байсан ба эрх баригчид албан хүчээр биеэ

үнэлснээс хойш цагдаад хандалгүй 30-аас дээш хоносон хэн нэгэнд, түүнчлэн албан хүчээр биеэ үнэлэхийн өмнө худалдаалагч этгээдээс зугтсан эмэгтэйчүүдэд туслалцаа үзүүлэхээс татгалздаг байлаа.

Хүн худалдаалахын эсрэг арга хэмжээ эрхийг нь шууд хөндөж байгаа хоёрдахь бүлэг хүмүүсийн тоонд амьжиргаагаа залгуулах гэж гэр орноосоо хол яваа маш олон хүн, амьдрал хайж бусад оронд гарсан буюу өөрийн оронд хэсч яваа сая сая хүн багтана. Олон газар оронд, ялангуяа Энэтхэг, Бразил мэтийн томоохон орнуудад олон нийт “хүн худалдаалах” гэдгийг хилийн чанадад яваа хүмүүсийг доромжлохтой холбож ойлгодог боловч өөрийн орны дотор яваа хүмүүст аюул эрсдэл учруулах, тэднийг доромжлон гутаах явдал ч ноцтой үйлдэл байж болно гэдгийг хэд хэдэн бүлэгт тодорхой харуулсан байна.

Үнэндээ худалдаалагдаж байгаа олонхи хүмүүс амьдрах аргаа хаа нэгтээ олох гэж гэр орноо санаатай орхин гарсан байдаг. Тэднийг хямд нүүдэлчид (economic migrants) гэдэг. Гэхдээ шилжиж очсоны үр дүн нь худалдаалагдсан хүмүүс болон бусад шилжин суугчдын хувьд өөр өөр байдаг. Бусад шилжин суугчид голдуу албан бус секторт ажиллаж амьдрах боломж хайдаг бөгөөд эцэст нь маш бага хөлстэй ажил олдож магадгүй ч хүний наймаа (түүнчлэн албадан хөдөлмөр болон боолчлол)-ны дотоод шинж болох хүчирхийлэл, эрх чөлөөгүй байдал болон бусад төрлийн хүнд доромжлолд өртөхгүй байж болно. Гэсэн хэдий ч тэдний өөрсдөө орж болох бэрхшээлт байдал ижилхэн бөгөөд, хэд хэдэн хэсэгт дурдсанаар, янз бүрийн бүлгүүдийг ангилан ялгахдаа засгийн газрын байгууллагуудын хэрэглэдэг шалгуур нь зохистой бус, тэр ч бүү хэл ялгаварлан гадуурхсан шинжтэй бөгөөд олонхи засгийн газрын тавьж буй хүчин чармайлт хүмүүсийг худалдаалагдахаас хамгаалж буй нэр төдий боловч гол нь шилжилт хөдөлгөөнийг “хянах” болон хязгаарлахад голлон анхаарч, шилжин суугчдад туслалцаа, хамгаалалт үзүүлэхгүй байх нь олонтаа байна. Үнэн хэрэгтээ олон оронд хүн худалдаалах явдалд бага анхаарч байгаа нь эдийн засгийн албан бус сектор дахь улирлын ажилчдад тулгарч байгаа бүх төрлийн доромжлол, хатуу ширүүн харьцааг эцэс болгох талаар юм хийхгүй байгаагаа зөвтгөх гэсэн үйлдэл юм шиг байна.

НҮБ-ын Хүн худалдаалахын эсрэг Протоколыг хүлээн зөвшөөрсөн орнуудын засгийн газрууд яагаад ихэнх хүч чармайлтаа хувь хүмүүсийг мөлжих

тохиолдлыг үгүй болгоход биш тэднийг мөлжлөгөд өртөж болох нөхцөл байдалд орохыг нь зогсооход гол анхаарлаа хандуулж байна вэ гэдэг нь сонин. Энэхүү түүвэр бичвэрийн олон бүлэгт өгүүлснээр НҮБ-ын Хүн худалдаалахын эсрэг Протоколд дурдсан мөлжлөгийн төрөл бүрийн хэлбэрийг дарж устгахад бус худалдагдаж байж болох (гэвч бас зүгээр л энгийн шилжин суурьшигч байж болох) хүмүүсийг барьж авахад илүүтэй хүч чармайлт тавьж байна. Тиймээс ч хүн худалдаалахын эсрэг олон арга хэмжээнд нэгэнт худалдаж авсан тэдгээр хүмүүсийг боолчлох буюу хүчээр хөдөлмөрлүүлэх зарим хэлбэрээр өөрт барьж, мөлжиж байгаа эмсийн хүрээлэнгийн эрхлэгч буюу ажилтнуудыг яллан шийтгэх бус, харин хүмүүсийг элсүүлж, нэг газраас нөгөө газарт аваачиж байгаа зууч этгээдүүдийг цээрлүүлэхээр тусгагдсан байдаг. Голдуу хүүхэд, эмэгтэйчүүд л хүн худалдаалахын эсрэг арга хэмжээнд шууд өртөн хохирч байгаа бөгөөд Хүн худалдаалахын эсрэг НҮБ-ын Протоколын “эмэгтэйчүүд ба хүүхэд”-ийг голлон анхаарсан тэр хэсэг зөвхөн хүүхэд, эмэгтэйчүүд л худалдагдах эрсдэлтэй байдгийг олон орны эрх баригчдад ойлгуулж өгсөн. Хүмүүсийг худалдаалагдахаас сэргийлэх нэрээр тэднийг өөрийн оршин суугаа газраа орхин явахыг болиулах арга хэмжээ авдаг нь үлэмж ноцтой асуудал юм. Ийм арга хэмжээний гол нь насанд хүрсэн эмэгтэйчүүд болон хүүхдүүдэд чиглэж байдгаас тэдний чөлөөтэй зорчих болон аж амьдралаа залгуулах эрх зөрчигдөж байна.

Ийм арга хэмжээний гол золиос нь албадан биеийг нь үнэлүүлэх зорилго агуулсан хүний наймаачдын гол бай болдог өсвөр насны охид, бүсгүйчүүд байгаа юм. Ихэнх тохиолдолд юу юунаас өмнө охид бүсгүйчүүд буюу бусад тодорхой бүлгийнхний чөлөөтэй зорчих эрхийг аливаа шаардлагагүйгээр хязгаарладаг аж. Бирмд ийм арга хэмжээ авч хэрэгжүүлснээс хойш бараг арван жилийн дараа АНУ-ын ТББ-ын санхүүжүүлжлэтээр хэрэгжиж буй хөтөлбөрийг хянаж үзэхийг хүсэлт болгосон нэгэн шинжээчийн дүгнэснээр бүсгүйчүүдийг Бирмын хил давж Энэтхэгт очих явдлыг таслан зогсоох гэсэн арга хэмжээ үндсэндээ хор хөнөөлтэй байжээ (Hausner, 2005). Тэрхүү шинжээч мэргэжилтний үзэж буйгаар охид, бүсгүйчүүд хил давах, түүнийг нь таслан зогсоох ёсгүй хууль ёсны үндэс шалтгаан байдаг байна. Жишээ нь, Энэтхэг рүү явж буй олон бирм хүүхэн ажил хайх бус хань нөхөр дээрээ очихоор явж байдаг бөгөөд энэ тохиолдолд худалдаалагдах боломж өндөр байдаг хэдий ч хил давж буй охид, бүсгүйчүүд нутаг орондоо байгаа

хүмүүсээс илүүтэй худалдагдах эрсдэлд ордог талаар нотлох баримт сэлт байхгүй байгаа юм.

Энэхүү түүвэр бичвэрийн хэд хэдэн бүлэгт шилжин явж буй эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах байдлаар барьж хорьдог тухай тодорхой дурдсан байна. Зарим улс оронд (Бирм ба Нигерид) ялгаварласан арга хэмжээг эх нутгаа орхин гарахаас нь өмнө авдаг аж. Бусад тохиолдолд залуу бүсгүйчүүдийг өөр бусад оронд очмогц (Бразил болон Нигерээс Европт ирж буй эмэгтэйчүүдийг) боломжийн биеэ үнэлэгч юмуу хүний наймаачдын золиос гэсэн ул болсон үзэл буй. Австралийн тухай нэг бүлэгт дурдахдаа эрэгтэйчүүд албадан хөдөлмөр эрхэлж буй нь тодорхой ч тэднийг худалдагдсан гэж тодорхойлох нь ховор учраас энэ ангилалд ордоггүй байна. Тийм учраас эрэгтэйчүүд эмэгтэйчүүдтэй ижил үйлчилгээнд хамрагдах эрхгүй байдаг. Хүн худалдаалахын эсрэг арга хэмжээ нь эрэгтэй, эмэгтэй хүмүүст адил бус нөлөөлдөг учраас амьдрал дээгүүр, илүү боловсролтой эмэгтэйчүүдийг бодвол ядуу дорой эмэгтэйчүүдэд нэн илүү муу нөлөөтэй гэдэг нь тодорхой юм.

Худалдаалагдсан хүмүүс болон амьдрал хөөж шилжин суурьшигчдын ард хүн худалдаалахын эсрэг арга хэмжээнд илүүтэй хүнд өртөж буй гуравдахь бүлэг хүмүүс бол суугаа орондоо болон хилийн чанадад бэлгийн ажил эрхэлж буй хүмүүс юм. Энэтхэг мэтийн зарим оронд хүний худалдаа гэдгийг тодорхойлохдоо 2000 онд баталсан НҮБ-ын Хүн худалдаалахын эсрэг Протоколыг бус өмнө нь гарсан Хүн худалдаалахыг хориглох тухай НҮБ-ын Конвенцийг уг үндэс болгодогтой энэ нь зарим талаараа холбоотой. Түүнчлэн энэ нь Хүн худалдаалахын эсрэг НҮБ-ын Протоколыг соёрхон баталсан улс оронд ч (Бразил мэтийн) хууль сахиулагчдад өгсөн заавар удирдамж нь хэдийгээр хүчээр дарангуйлах буюу хууран мэхлэх арга хэрэглээгүй ч бэлгийн ажлыг хүн худалдаалах явдалтай адилтган үзэж буй эсэхтэй бас холбоотой. Олон улс орон эмэгтэйчүүд болон охидыг өөрсдөө зөвшөөрсөн, зөвшөөрөөгүй эсэхээс үл хамааран биеэ үнэлэх ажилд элсүүлсэн хэн нэгнийг шийтгэх бодлогыг барьж эхэлсэн 1930-аад оноос хойш энэ нь 1933, 1949 онд батлан гаргасан олон улсын конвенцүүдтэй²⁰ нийцэж байгаа юм. Хэдийгээр Хүн худалдаалахын эсрэг НҮБ-ын Протоколд өмнө нь батлагдсан Хүн худалдаалах явдлыг хориглох тухай НҮБ-ын Конвенцид дурдсан биеэ үнэлэх явдлыг илтэд зэмлэн буруушаасан буюу биеэ үнэлэх

явдлыг таслан зогсоох ёстой гэсэн заалтыг давтаагүй болохоор үүнийг бэлгийн ажил эрхлэгчид өмнөх олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн дагуу авч буй арга хэмжээнүүдийг бодвол Хүн худалдаалахын эсрэг НҮБ-ын Протоколыг хэрэгжүүлэхийн чиглэлээр авч байгаа арга хэмжээнүүдээс бага хор хохирол амсах ёстой гэж үзэх нь ухаалаг хэрэг юм шиг байна. Гэхдээ энэхүү төрлийн хэргийг тайлбарласан нотлох баримт бага байгаа юм. Үнэндээ Бразилын тухай бүлэгт тус орон Хүн худалдаалахын эсрэг НҮБ-ын Протоколыг соёрхон баталсан хэдий ч хууль тогтоомжид саяхны оруулсан нэмэлт өөрчлөлтүүд нь юутай ч гэсэн Бразил улс оролцогч тал хэвээр байгаа Хүн худалдаалах явдлыг хориглох тухай НҮБ-ын өмнөх Конвенцид тулгуурласан гэдгийг тодорхой заасан байна.

Энэхүү илтгэлийн гол ололт

Бүлэг тус бүрт хууль тогтоомжууд буюу засгийн газрын бодлого үүнээс ашиг тус хүлээсэн тэр ард олны заримт хэсэгт сөрөг үр дагавар авчирч байгаа олон жишээг дурджээ. Энд гурван өөр төрлийн нөлөөлөл буйд гол анхаарлаа төвлөрүүлэх хэрэгтэй юм шиг. Нэгдүгээрт, худалдаалагдсан хүмүүст туслалцаа, хамгаалалт үзүүлэх бодлогын нөлөө хууль сахиулах албан тушаалтнуудтай яаж хамтран ажиллаж байгаагаас шалтгаалж байна. Хоёрдугаарт, хүн худалдаалахын эсрэг арга хэмжээнүүд шилжин суурьшигч болон бусад хүмүүст хор нөлөө үзүүлж байна. Гуравдугаарт, “хүн худалдаалах” үзэл баримтлалыг буруу тайлбарлан хэрэглэж байгаа нь засгийн газруудын авч хэлэлцвэл зохих улстөрийн асуудлуудад нөлөөлж байна. Тиймээс бие даасан олон бүлэг, хэсгүүдэд дурдсан бөгөөд 2001 оноос хойш АНУ-ын Засгийн газраас дэлхий даяар явуулсан урьдчилан сэргийлэх кампанит ажлын үзүүлж буй нөлөөг эргэж харах нь чухал шиг байна.

Худалдаалагдсан хүмүүст үзүүлэх туслалцааг хууль сахиулагчидтай хамтран ажиллах явдлаас хараат болгох нь

Дэлхийн улс орнуудад худалдаалагдсан хүмүүст үзүүлэх туслалцаа болон хамгаалалтыг хүртээмжтэй болгох явдлыг тэдний зүгээс хууль сахиулагчидтай хамтран ажиллах, сэжиг бүхий хүний наймаачдыг мөрдөн

шалгахад нотлох баримт болгон ашиглах бүрэн боломжтой өргөдлийг тэдэнд гаргаж өгөхийг зөвшөөрөх явдалтай нь уялдуулан авч үзэж байлаа. Хууль зүйн баримт бичиг нь худалдаалагдсан байж болзошгүй хэн бүхэнд хамгаалалт үзүүлэх явдлыг баталгаажуулсан улс оронд ч (Босни ба Герцогевин мэтийн) хууль сахиулах байгууллагууд хэнд эрхийг нь эдлүүлэх ёстойг шийдэх байр сууринд өөрсдийгөө зоргоороо тавьж байна. Зэвүүцэл төрмөөр ийнхүү хандах нь хүний эрхийг үгүйсгэж байгаа хэрэг юм. Цаашилбал, ижил төрлийн баримт нотолгоо харуулж байгаагаар энэ нь хууль сахиулах ажиллагаанд түр зуурхан ашигтай байгаа ч туслалцааг хууль сахиулагчидтай хамтран ажиллах явдлаас хараат байлгах урт хугацааны практик ажиллагаа нь худалдаалагдсан хүмүүсийг хууль сахиулах байгууллагуудын сэжигтэн болгох, тэдгээрийн аж байдлын талаар нээлттэй ярихад дургүйцэх, улмаар мөрдөн шалгаж туслахаасаа илүүтэй саад тээг болоход нь дэм болж байна.

Энэхүү түүвэр бичвэрт дурдсан өөр үндэсний хүмүүс худалдаалагдаж байгаа аж үйлдвэржсэн орон (Австрали, Нэгдсэн Вант Улс болон АНУ) болгонд үзүүлж буй туслалцаа, хамгаалалт дээрх байдалтай байгаа юм. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл, олон тохиолдолд, бие, сэтгэлзүй, сэтгэл санааны хувьд мөрдөн шалгах буюу шүүн шийтгэх ажиллагаанд туслах чадваргүй худалдаалагдсан хүмүүсийг асууж шалгааж байна. Европт хийсэн саяхны судалгаа харуулж буйгаар худалдаалагдсан эмэгтэйчүүдийн гуравны нэг нь хүний наймаачдын хяналтаас гарсны дараа наад зах нь хоёр долоо хоногийн турш ой ухааны хувьд бэрхшээлтэй байдгаас энэ хугацаанд тэд өөрсдийн амссан хамгийн гол бие, сэтгэлийн гэмтэл буюу хохирлын талаар нотлох баримт гарган өгч чаддаггүй ажээ (Zimmerman, 2006, 21).

Хууль сахиулагчидтай хамтран ажиллах явдал нь хэрвээ энэ хамтын ажиллагааны талаар хүний наймаачид болон тэдний хамсаатнууд олж мэдэх юм бол худалдаалагдсан хувь хүмүүс буюу тэдний ойрын төрлийнхний аюулгүй байдалд аюул эрсдэл учруулдаг. Цаашилбал, энэ нь худалдаалагдсан хүнд туслалцаа үзүүлэх эсэх, үзүүлбэл хэзээ үзүүлэх шийдвэр нь доромжлол хэдүйнээ амссан хүний эрхэд үл хамаарах хүчин зүйлс, бас хөрөнгө мөнгөний дарамт гачигдал буюу шүүх дээр тодорхой үр дүнд хүрэх хамгийн сайн арга зам зэрэг хүчин зүйлст тулгуурладаг байна. Хэрэг дээрээ энэ нь худалдаалагдсан хүний эрх болон хэрэгцээ шаардлагыг

мөрдөн байцаагчид буюу яллагчдын үр дүнтэй ажиллагаа, хувийн зан чанараас хараат болгож байна. АНУ-ын талаарх бүлэгт яллагчид хүний наймаачдыг мөрдөн шалгахдаа холбооны бус муж улсын хуулийг сонгодог учраас л худалдаалагдсан хүмүүс хамгаалалт эдэлж чадахгүй байгаа тохиолдлыг ишлэн дурдсан байна.

Ийм нөхцөлт чанарын ард буй онолын үзэл баримтлалыг хүний эрх ч юмуу, шүүн таслах ажиллагааны үүднээс ойлгоход хэцүү. Энэ нь гэмт хэрэг болон эрх мэдлээ урвуулан ашигласан хэргийн хохирогсодтой хэрхэн харьцах талаарх бусад зарчим, тухайлбал *Гэмт хэрэг болон эрх мэдлээ урвуулан ашигласан хэргийн хохирогсодод хандах Шударга ёсны үндсэн зарчмуудын тухай НҮБ-ын Тунхаглал (1985)*²¹-д дурдсан зарчмуудтай бүрнээ зөрчилдөж байгаа юм. Тус Тунхаглалд “Хохирогсодод засгийн газар, сайн дурын, олон нийтийн болон тухайн нутаг орны арга хэрэгслээр эд материалын, эмнэлгийн, сэтгэлзүйн болон нийгмийн шаардлагатай туслалцаа үзүүлбэл зохино” хэмээн заасан байна (14 дүгээр зүйл).

Зарим улс орон худалдаалагдсан хүмүүст хоромхон зуурын “бодох хугацаа” олгох замаар туслалцааг болзолт шинжтэй болгохтой санал зөрдөг явдлыг шийдвэрлэх оролцлого хийсэн. Эдгээр нь хууран мэхлэгдсэн, барьж хорьсон, эрүүдэн шүүсэн, хүчиндүүлсэн, тархийг нь угаасан буюу өөрсдөөсөө мөнгө гаргахыг шахан шаардсан бусад нөхцөл тулгасан хувь хүмүүст мэдээллийн үндсэн дээр амьдралаа эргэж хянах болон өөрсдийгөө болон хайр дуртай хүмүүсээ эрсдэлд оруулах эсэхээ шийдэх адил тэгш боломж олгож байгаа хэрэг гэж үздэг. Гэхдээ худалдаалагдсан хүмүүст олгож байгаа “бодох” хугацаа нь ерөнхийдөө эмч мэргэжилтнүүд өвчтөнүүдээ эдгэрч, амьдралдаа хяналт тавьж чаддаг болно гэж тооцоолсон хугацаанаас богино юм.²²

Доромжлогдсон хүнд үзүүлж байгаа ийм муухай шахалт дарамтыг хууль сахиулагчид болон улстөрчид хүлцэх янз бүрийн учир шалтгаан бий. Нэгдүгээрт, засгийн газрууд үүнийг доромжлогдож хохирсон хүмүүст чухал шаардлагатай туслалцаа үзүүлнэ гэхээсээ өмнө хууль бус цагаачлалыг зогсоох нэн тэргүүний арга хэмжээ гэж үздэг. Нөхцөл тавиагүй хамгаалалт, туслалцаа үзүүлэх нь хуурамч хүсэлт гаргагчдад эх оронд нь үлдэх шинэ суваг нээнэ гэж тэд мэтгэдэг.

Хоёрдугаарт, хэдийгээр НҮБ-аас хүн худалдаалахыг 2000 онд тодорхойлсон ба одоо энэхүү тодорхойлолт олон орны хууль тогтоомжид орсон ч хууль

сахиулагчид “хүн худалдаалах” гэдгийг биеэ үнэлэх, ялангуяа бусад орноос ирсэн эмэгтэйчүүдийг хамруулсан бэлгийн ажилтай адилтган үзэж байна. Улаан дэнлүүний дүүрэгт явуулсан тоо тоймшгүй олон “аврах” ажиллагааны явцад цагдаад баривчлагдсан “хохилогчид” худалдаалагдаагүй боловч мөнгө олох гэж эргэн ирж суурьшсан бэлгийн ажил эрхлэгчид байсан бөгөөд тэднийг ажил олгогчдоос нь хамгаалалгүй дан биеэр нь нутаг оронд нь буцаасан байна. Ийм хүмүүс өөрсдийг нь эрүүгийн элемент бус хамтран зүтгэгч гэж үздэг хүмүүсийнхээ эсрэг мэдүүлэг өгөх дүргүй байдагт нь гайхах бараг хэрэггүй.

Хууль сахиулагчид хүний наймаачдыг барьж шийтгэхэд шаардлагатай нотлох баримт цуглуулах гэж бэрхшээлтэй тулгардаг нь тодорхой. Гэхдээ амьдрал дээр худалдаалагдан мөлжигдөж байгаа хүмүүсийг албан шахалтаар шууд хамтран ажиллахад татан оруулах хүчин чармайлт мөрдөн шалгах ажиллагаанд ашиглах нотлох баримт гаргахтай бараг холбоогүй юм. Худалдаалагдсан олон хүн хүндрэлтэй байдалд өөрсдөө ордогтой энэ нь зарим талаар холбоотой. Тэдгээр нь Хүн худалдаалахын эсрэг НҮБ-ын Протоколын тодорхойлолтод хамаарагддаг “цэвэр хохирогч” биш боловч нууцаар хил нэвтрэх буюу хууль бусаар мөнгө олохыг зөвшөөрсөн хүмүүс байдаг. Үнэндээ тэдний зарим нь бусдыг худалдаалахад хамсан оролцдог. Энэ бүхэн нь тэднийг хууль сахиулагчидтай хамтран ажиллахаас эмээн болгоомжлоход хүргэдэг байна. Түүнээс гадна зарим нь ноцтой доромжлол амсдаг ба цагдаа буюу яллагч нартай хамтран ажиллах хүсэлт тавих яг тэр мөчид гэмтлийн дараах стрессийн хам шинжээр шаналж байдаг.

Хууль сахиулагчдад тулгардаг бэрхшээлийг шийдвэрлэхийн тулд нотлох баримт цуглуулах болон худалдаалагдсан хүмүүст хамгаалалт, туслалцаа авах бүрэн дүүрэн эрхийг нь баталгаажуулах болон зөвхөн бие нь сайжрах болон айх аюулгүй болсон үед нь нотлох баримт гаргаж өгөх талаар ярих мөрдөн шалгалтын өөр өөр арга сонгож хэрэглэх явдал мөн нь бараг эргэлзээгүй.

Хүн худалдаалахын эсрэг арга хэмжээний бусад бүлгийн хүмүүст үзүүлэх нөлөө

Энэхүү түүвэр бичвэрийн бүлгүүдэд харуулж байгаагаар хүн худалдаалахаас сэргийлэх зарим хүчин чармайлт худалдаалагдсан хүмүүсийн эрх чөлөөг хангах нэлээд хэдэн санаачлагатай нийлээд бусдад үлэмж хохирол

учруулсан. Худалдаалагдсан хүмүүсийг олж тодорхойлох болон тэднийг худалдаалагч буюу мөлжигч этгээдийн гараас салгаж авах үйл явц найрсаг ээлтэй бус бөгөөд бусадтай шаардлагагүйгээр хатуу ширүүн харьцахад хүргэж байна. Ялангуяа сэжиг бүхий дэн буудал (баар буюу дэн буудал маягаар ажилладаг бусад газрууд)-д гэнэтийн шалгалт, баривчилгаа хийх тухайд ийм байдаг.

Зарим ажиллагаа “зорилго нь аргаа зөвтгөнө” гэсэн засгийн газрын бодлогод үндэслэдэг бол Хүний эрхийн Хороо Чөлөөтэй зорчих эрх чөлөөний тухай Ерөнхий Тайлбар 27-доо гол болгосон зарчмууд нь хүн худалдаалахын эсрэг арга хэмжээний “дагалдах хор хохирлыг” багасгахын тулд эдгээр арга хэмжээг эргэж харах хойшлуулшгүй шаардлага байгааг сануулжээ. Ялангуяа урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүд хүмүүсийг нутаг орноо орхиж явахгүй буюу шилжин суурьшихгүй байхыг ухуулах үед байдал яг ийм байдаг. Худалдаалагдсан хэмээн сэжиглэгдэж буй хүмүүсийн эрх чөлөөг хангах үүднээс гэнэтийн шалгалт, баривчилгаа хийх болохоор хүний эрхийн үндэсний байгууллагууд (засгийн газар омбудсмен болон комиссуудыг томилдог) хатуу ширүүн харьцах буюу эрх мэдлээ урвуулан ашиглахыг зогсоох анхны алхмуудыг хэдүйнээ авсан байдаг. Ази, Номхон далайн хүний эрхийн үндэсний байгууллагуудын Форумас 2005 онд зохион байгуулсан хүн худалдаалах асуудлаарх семинар гэнэтийн шалгалт, баривчилгаа явуулах үед гарч байгаа хүний эрхийг бүдүүлгээр зөрчиж буй талаар сэтгэл зовниж буйгаа илэрхийлж, хүний худалдааны золиос болж хохирогчдын хүний эрхийг хамгаалах явдлыг хангах зорилгоор хийх гэнэтийн шалгалт болон баривчилгаа, аврах ажиллагаанд холбогдох байцаан шийтгэх ажиллагааг журамласан удирдамж боловсруулж гаргахыг зөвлөмж болгосон.²³ Жишээ нь уг семинараас худалдаалагдсан хүмүүсийг хамгаалах зорилго бүхий гэнэтийн шалгалт, баривчилгааг зохих ёсоор урьдчилан төлөвлөхгүйгээр явуулж болохгүй ба худалдаалагдсан сэжиг бүхий насанд хүрсэн хүмүүсийг өөрсдөө хүсвэл зөвхөн тэр байдлаас нь авч гаргавал зохино гэсэн санал дэвшүүлсэн.

“Хүн худалдаалах” үзэл баримтлалыг буруу тайлбарлаж хэрэглэснээс улстөрийн хэлэлцэх асуудалд дэм нөлөө үзүүлж байна

Засгийн газрууд болон бусад байгууллагууд онолын эдгээр үзэл баримтлалыг олон улсын эрхзүйд тодорхойлоогүй ч тэдний бодлого,

хандлага худалдаалагдсан хүмүүсийн хүний эрхийг гол болгон хүндэтгэдэггүй атлаа хүн худалдаалахын эсрэг өөрсдийн хийж буй ажлыг “эрхэд үндэслэсэн” буюу “хүний эрхийг эрхэмлэх хандлагад суурилсан” гэж нурших нь бий. Гэхдээ амьдрал дээр дэлхий нийтээр засгийн газрууд худалдаалагдсан буюу худалдаалагдах өндөр эрсдэлтэй хүмүүсийн эрх ашгийг умартан хүн худалдаалах асуудлыг улстөрийн хэлэлцэх хэргээ хүчтэй болгон эрчимжүүлэхэд ашиглаж иржээ. Түүний улмаас хүн худалдаалахын эсрэг хүчин чармайлт шилжин сууршигчид, эмэгтэйчүүд болон бэлгийн ажил эрхлэгчдийн эрхийн байдалд хамаарах засгийн газрын үйл ажиллагааны тодорхой гурван салбарт сөрөг нөлөө үзүүлж ирсэн байна.

Цагаачлал

Засгийн газрууд “хүний худалдааны золиос бологсодыг аварсан” хэмээн зарлан тунхаглахдаа *хүн худалдаалах* гэсэн нэр томъёог ашиглан тухайн хувь хүмүүсийн хүсэл зорилгыг хайхралгүйгээр, тэндээ үлдэх хүсэлгүй, мөн тийм эрхгүй хүмүүсийг нутаг оронд нь хүргэж байгаа гэж тайлбарладаг. Төр, засгийн байгууллагын эрх мэдэлтнүүд *хүний худалдаа* гэсэн үгийг ашиглаж, “*аварч байна*”, худалдаалагдсан хүмүүст туслаж байна гэх боловч хэрэг дээрээ тэдгээрийн санал хүсэлтийг авалгүй, хүчээр нутаг буцаадаг ажээ. Нигерийн тухай бүлэгт Италиас албадан нутаг буцааж байгаа жишээнүүдийг дурдаж, мөн хөрш зэргэлдээ Бенин улсаас ирсэн 26 залуу хүнийг 16-17 насны 48 өсвөр насныхантай хамт хүчээр нутаг буцаасан тухай бичжээ. Хэдийгээр бүс нутгийн гэрээгээр тэдний Нигерид буюу өөр ажил хайх сонголтыг хүлээн зөвшөөрдөг ч тэдний нэгэнд ч тийм боломж олгоогүй байна. Тэднийг нэг газарт цугтаа ажил эрхэлж байсан бүлэг залуу хөвгүүдийн хамт нутгаасаа яаралтай хөөж гаргажээ. Үүнтэй төстэй байдлаар төр, засгийн албан тушаалтнууд зарим тохиолдолд “хүний худалдаа” хэмээх нэр хаяг зүүж, эдгээрт хөдөлмөрлөх ердийн эрх хамаарахгүй бөгөөд уламжлал ёсоор хөдөлмөрлөх эрхийг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэдэг үйлдвэрчний эвлэл мэтийн байгууллагууд эдгээр эрхийг дэмжихэд үүрэг гүйцэтгэхгүй хэмээн далдуур хэлдэг юм. Энэ нь эргээд худалдаалагдаж эрх нь зөрчигдсөн хүмүүсийг дэмжин хамгаалагчдын тоог цөөрүүлэх нөлөө үзүүлж, тэгснээрээ тэр эрэгтэй болон эмэгтэйн хохирлыг барагдуулах буюу шүүхэд хандах боломжийг нь багасгаж байгаа юм.

Цагаачлалд анхаарал тавьж байгаа нь аж үйлдвэржсэн ийм олон орон яагаад өөрийн хил доторх мөлжлөгийг зогсоох чиглэлээр хүчин чармайлт гаргахаасаа өмнө шилжин суугчид хаанаас ирж байгаа тэр оронд нь хүн худалдахаас сэргийлэх санаачлагад илүүтэй анхаардгийн гол учир шалтгаан мөн нь эргэлзээгүй (Австрали улс Зүүн Өмнөд Ази дахь санаачлагыг санхүүжүүлдэг ба Нэгдсэн Вант Улс Зүүн Өмнөд Европт авч хэрэгжүүлж буй санаачилгыг дэмждэг). Гэхдээ үүний улмаас эдгээр оронд ядуу орнуудаас хүмүүс шилжиж ирэхээс юуны өмнө сэргийлэхийн тулд худалдагдах аюул эрсдэлээр бамбай барьдаг ч мөлжлөгийн загвар, түүний дотор албадан хөдөлмөрт харьцангуй бага анхаардаг. Боломжийн шилжин суурьшигчид хүн худалдаалахын эсрэг олон сурталчдыг нэлээд хэмжээгээр үл ойшоох болсныг нэгэнтээ мэднэ (Limanowska, 2005, 31).

Жендер

Аж үйлдвэржсэн орнуудын цагаачлалын алба эмэгтэйчүүд, охидыг ялгаварлан гадуурхдагийг өмнө нь дурдсан билээ. Цагаачлалын албад Бразил, Нигери мэтийн зарим орноос зорчин ирж буй бүсгүйчүүдийг магад бэлгийн ажил эрхлэгчид буюу хүний худалдааны золиос бологчид хэмээх ул болсон ойлголттой бөгөөд тэднийг оруулахдаа (буюу тэднийг чөлөөтэй зорчиход нь) үүнийгээ саад тээг болгох уучлалт маягаар ашигладаг. Эмэгтэйчүүдийг хүний худалдааны золиос бологчид хэмээн үзэх нь илүүтэй байдгаас аж үйлдвэржсэн орнуудын эрх баригчид эрэгтэй хүн худалдагдаж болох боломжийг огоорон, улмаар албадан хөдөлмөрийн бүхий л золиос бологчдоос илүүтэй эмэгтэй хүнийг үйлчилгээ, хамгаалалтаас хасдаг байна.

Хөгжиж буй зарим оронд ядуу гаралтай эмэгтэйчүүдийн гар хөдөлмөр эрхлэх эрхийг нь үгүйсгэдэг байхад мэргэжил, мэдлэгтэй чинээлэг эмэгтэйчүүдийг хилийн чанадад ажиллахыг нь зөвшөөрдөг. Илүү ерөнхийлж хэлбэл, хүн худалдаалахын эсрэг санаачилгууд нь эмэгтэйчүүдийг идэвхгүй, шийдвэр гаргах чадваргүй, хамгаалалт шаардах хүмүүн гэсэн ойлголтыг төрүүлж байна. Тэд зарим ангиллын шилжин суурьшигчдыг оруулахад саад болох халхавч болдог. Тэд эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалахыг шаардахдаа эмэгтэйчүүдийн эрхийн байдал болоод тэгш байдалд хор учруулж байна.

Бэлгийн ажил

Хэдийгээр Хүн худалдаалахын эсрэг 2000 оны НҮБ-ын Протоколд “хүн худалдаалах” гэдгийг тодорхойлсон боловч зарим засгийн газар уг томъёоллыг өөрөөр сонгон тодорхойлж байна. Хүн худалдаалахын эсрэг НҮБ-ын Протоколоос хоёр жилийн дараа Хүн худалдаалахыг хориглох тухай НҮБ-ын өмнөх Конвенцийг үндэс болгосон бөгөөд Хүн худалдаалахын эсрэг Протоколын тодорхойлолттой зөрчилдсөн заалт бүхий бүс нутгийн конвенци (Бүс нутгийн хамтын ажиллагааны Өмнөд Азийн холбоо [SAARC]-ны *Эмэгтэйчүүд, хүүхдийг биеийг нь үнэлүүлэх зорилгоор худалдаалахаас сэргийлэх, тэмцэх тухай Конвенци, 2002*) батлан гаргасан Өмнөд Азиас үүнийг нэн тодорхой харж болох юм.

Хүн худалдаалахын эсрэг НҮБ-ын Конвенцийг соёрхон баталсан бусад орон хүн худалдаалахын эсрэг үйл ажиллагаандаа мөлжлөгийн нэгэн тодорхой хэлбэрийг (тухайлбал бусдын биеийг үнэлүүлж мөлжих) сонгож, илүүтэй анхаарал хандуулж байгаа нь бусад хэлбэрээр мөлжих зорилгоор хүн худалдаалах явдалд бага буюу огт анхаарал тавихгүй байгааг харуулж буй бөгөөд хүчээр биеийг нь үнэлүүлэхээс бусдаар албадан хөдөлмөрлүүлэх зорилгоор худалдаалагдсан хувь хүмүүс зохих ёсны хамгаалалт болон туслалцааг гол төлөв авч чадахгүй байна гэсэн үг юм. Хүн худалдаалахын эсрэг НҮБ-ын Протокол байдаг хэдий ч хүн худалдаалахын эсрэг арга хэмжээг хүмүүсийг хүчээр биеийг нь үнэлүүлэх тодорхой нөхцөл байдлаас бусдаар ерөнхийдөө бэлгийн ажлыг хориглоход чиглэсэн олон арга хэмжээг зөвтгөхөд ашиглаж байна.

Хэдийгээр GAATW-г дэмжигчдийг оролцуулаад хүн худалдаалахын эсрэг үйл ажиллагаа явуулж буй идэвхтнүүдийн цаад санаа зорилго сайн ч тэд хүн худалдаалахаас сэргийлэх болон худалдаалагдсан хүмүүсийг хамгаалахын тулд өөрсдийн урдаа тавьсан үйл ажиллагааны хүрээг нууц буюу тийм ч ил тод бус үйл ажиллагаанаасаа салган зааглаж чадахгүй байна. Тус бичвэрийн бүлгүүд харуулж байгаагаар үүний үр дүнд хүн худалдаалахын эсрэг үйл ажиллагаа нь худалдаалагдсан хүмүүст тийм ч сайн үр дүн авчрахгүй байгаа бөгөөд бэлгийн ажил үйл эрхэлж байгаа шилжин явагчид болон эмэгтэйчүүдэд ихээхэн хор учруулж байна. 2001 онд хүн худалдаалахын эсрэг дэлхий нийтийн аян өрнүүлж, энэ ертөнцийн олон оронд нөлөөгөө үзүүлсэн АНУ-аас бусад ямар орон юу хийсэн талаар мэдэх зүйл алга.

АНУ-ын засгийн газраас дэлхий даяар өрнүүлсэн хүн худалдаалахаас сэргийлэх аян

2000 оны аравдугаар сард НҮБ-ын Ерөнхий Ассамблей Хүн худалдаалахын эсрэг Протокол батлахын өмнөхөн АНУ *Худалдаалагдаж хохирогсодыг хамгаалах Хууль-2000* (ХХХХ) батлан гаргасан билээ. Үүгээр АНУ-д үйлдэгдэж байгаа хүн худалдаалахтай холбоотой гэмт хэрэгт оноох ял шийтгэлийг чангатгасан юм. Түүнчлэн энэхүү хуульд бусад засгийн газруудын үйлдлийг хөхиүлэн дэмжих санаа бүхий чухал чухал заалт орсон. АНУ бусад засгийн газруудад шахалт үзүүлж байгаагаа зөвтгөхдөө энэ нь хүний эрхийн зарчмуудыг үндэс болгоно гээд:

АНУ-ын Үндсэн Хуулиар (Нэмэлт 13) Америкийн Нэгдсэн Улсад боолчлох буюу өөрийн мэдэлгүйгээр зарцлах явдлыг хориглоно. Хүн худалдаалах явдалтай олон улсын хэмжээнд тэмцэх хүчин чармайлтдаа бид энэхүү үндсэн жишиг зарчмыг хангахыг эрмэлзэнэ гэжээ.

Энэхүү Хууль батлагдсанаас хойш бусад орнуудад АНУ-ын санхүүжүүлсэн санаачилгын олонхи нь хүний эрхийг хүндэтгэн дээдлэх явдлыг дмжин урагшлуулсан нь эргэлзээгүй. АНУ-ын засгийн газрын өөрийн данс тооцоо харуулж буйгаар 2001-2006 онд 447 сая гаруй долларыг ийм хүчин чармайлтад зарцуулсан (US GAO, 2007, 1) бөгөөд зөвхөн 2005 онд 10 шахам орныг хамарсан байна. АНУ-д дотооддоо ХХХХ-ийн үзүүлж байгаа нөлөөний талаар АНУ-ыг голлон авч үзсэн бүлэгт дэлгэрэнгүй танилцуулжээ.

АНУ бусад засгийн газруудын нэгэн адилаар хүний худалдааг үгүй болгох тэмцэлдээ гэмт хэргийн эсрэг болон хүний эрхийн зорилтуудыг нэгтгэсэн хохирогч төвтэй хандлага баримтлахыг шаарддаг (АНУ-ын Төрийн Департамент, 2006, 22). Гэхдээ, практик түвшинд бусад засгийн газрууд ч баримтлах ёстой гэж АНУ-ын зүтгэсэн хандлага хүний эрхэд хүлээн авах аргагүй өртөг зардал гаргахад хүргэсэн. Ийм нэг арга хэмжээ бол биеэ үнэлэх явдлыг илтэд буруушаан зэмлэж чадахгүй байгаа аливаа байгууллагыг санхүүжүүлэхгүй гэсэн АНУ-ын засгийн газрын 2003 оны шийдвэр байлаа. Энэхүү арга хэмжээ эхлээд ХДХВ/ДОХ болон бусад өвчний эсрэг дэлхий нийтийн хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхтэй холбоотой 2003 оны АНУ-ын Хуульд тусгагдсан байсан. 2005 онд үүнийг шинэчилж,

Биеэ үнэлэх явдал буюу бэлэгсийн худалдааг хууль ёсны болгох буюу ийм ажиллагаа эрхлэхийг дэмжих буюу хамгаалахыг хориглох арга хэмжээ нэртэй болгосон (дэлгэрэнгүйг АНУ-ын тухай бүлгээс үзнэ үү). Энэ бодлого АНУОУХА мэтийн АНУ-ын засгийн газрын байгууллагуудыг бэлгийн ажил эрхлэгчдийн өөрсдийгөө хамгаалах зорилгоор байгуулсан аливаа байгууллага, түүнчлэн бэлгийн ажлыг хууль ёсны болгохыг дэмждэг аливаа байгууллагын ХДХВ/ДОХ буюу хүн худалдаалахын эсрэг явуулж байгаа аливаа ажлыг санхүүжүүлэхээс сэргийлж байгаа юм. Энэхүү арга хэмжээ арилжааны сексийг эсэргүүцдэг, мөн дэлхийн хаана ч гэсэн бэлгийн ажлыг хууль ёсны болгохыг буруушаан үздэг Ерөнхийлөгч Бушийн бодлогыг үндэс болгож байсан. АНУ-ын дэмжлэг хүлээсэн энэхүү бодлого бэлгийн ажлыг хууль ёсны болгох нь хүний худалдааг өөгшүүлнэ гэж үздэг. Үүнийг бусад олон хүн маргадаг юм. АНУ-ын засгийн газрын алба болох Засгийн газрын Тайлагналын Алба (GAO) үүнийг ач холбогдол бүхий нотлох баримтад тулгуурлаагүй байгааг тэмдэглэж,

Жишээ нь, Хүн худалдаалах тухай 2005 оны Илтгэлд хууль ёсны болгосон буюу зөвшөөрөгдсөн биеэ үнэлэлт нь арилжааны шинжтэй бэлгийн боолчлолд худалдаалагдан өртөж байгаа эмэгтэйчүүд, хүүхдийн тоог ямагт шахуу нэмэгдүүлж байгааг нотолж буй боловч түүнийг нь дэмжсэн аливаа баримтыг ишлэн дурдаагүй байна гэжээ.

Мөн АНУ бусад засгийн газруудад хандан, хүний наймаачдыг мөрдөн мөшгихөд тэргүүн зэргийн ач холбогдол өгөх ёстойг онцлон тэмдэглээд, хичнээн тооны ийм мөрдөн шалгах ажиллагаа явуулсан талаараа АНУ-ын ЭСЯ-дад жил бүр мэдээлж байхыг тэднээс шаардаж байна. Хэдийгээр онолын хувьд хүний наймаачдыг барьж авах, золиос бологчдыг тэдний гараас салгаж авахад хандах АНУ-ын хандлагыг “хохилогчдын эрхийг нэн тэргүүнд тавьж байна” гэж үздэг боловч амьдрал дээр энэ хандлага нь эн тэнцүүлэх зарчмыг (principle of proportionality) үл ойшоох байдалтай байгаа ба зорилго нь (хүний худалдааны золиос бологчдыг чөлөөлөх) аргаа зөвтгөнө гэсэн мессеж тараахад дөхөж очиж байгаа юм.

XXXX хүний худалдааг (АНУ-ын талаарх бүлэгт жагсаан дурдсан) устгах наад захын бүлэг стандартыг агуулж байна. Уг хуульд “хүний худалдааны хүнд хэлбэр” хэмээн нэрлэдэг зуугаас илүү шахуу хохирогч этгээдтэй гэж үздэг бүх орны засгийн газрууд эдгээрийг авч хэрэглэх боломжтой гэж АНУ-

ын эрх баригчид үзэж байна. Тус хуульд “хүний худалдааны хүнд хэлбэрүүдийг устгах урт хугацааны нухацтай хүчин чармайлтын шинж тэмдэг” гэж үзэх 10 хүчин зүйлийг жагсаан оруулсан байна. АНУ-ын Төрийн Департаментаас гаргадаг Хүний худалдааны Илтгэл (US TIP Report)-д эдгээрийг жилд нэг удаа үнэлдэг. Хамгийн сүүлчийн илтгэлийг 2007 оны зургадугаар сард нийтэлжээ. Энэ нь улс орнуудыг Tier 1 (АНУ-ын наад захын стандартуудыг бүрэн зөвшөөрч дагадаг)-ээс Tier 3 (зөвшөөрдөггүй) хүртэл дөрвөн бүлэг болгон ангилдаг. Tier 3 гэдэг ангилалд орвол АНУ-ын зүгээс хүмүүнлэгийн бус, худалдаатай холбоогүй туслалцаа үзүүлэхээс татгалзаж болох юм. Tier 2-ыг хоёр ангилах бөгөөд “Tier 2-ын хяналтын хуудас” гэж нэрлэдэг “доод 2” ангилалд орвол зэрэглэл бууруулах (буюу туслалцаагаа зогсоож магадгүй) аюултай.

US GAO “... АНУ-ын Төрийн Департамент эдгээр орныг оруулсан tier зэрэглэлийг зөвтгөхдөө гадаад орнуудын засгийн газар стандартуудыг зөвшөөрөн дагаж буй эсэхийг өргөн хүрээнд тайлбарлахгүй байгаа бөгөөд эдний ихэнх нь субъектив шинжтэй юм” хэмээн тайлбарлаж, улс орнуудыг тодорхой ангилалд оруулахад хэрэглэж байгаа шалгуурыг шүүмжилжээ (US GAO, 2006, 26).

Tier 3-т хүний худалдааны ноцтой хэлбэр бүхийгээсээ бус АНУ-тай муу харилцаатай бөгөөд тэдний зэрэглэл үүнээс улбаатай гэж сэжиглэдэг янз бүрийн орон багтаж байгааг жил бүрийн зэрэглэлийг шүүмжлэгчид тэмдэглэжээ. АНУ-ын хүний худалдааны талаарх Илтгэл 12 орныг Tier 3-т оруулсан байна. Тэдний дотор АНУ-ын эртний холбоотон Саудын Араб байгаа юм. Гэхдээ олон тооны иргэд нь хүний худалдаанд өртсөн гэж илтгэгдсэнээсээ бус засгийн газрууд нь АНУ-тай муу харилцаатай хэд хэдэн орон, тухайлбал Куба, Иран, Хойт Солонгос, Судан, Сири болон Венесуэл тэнд бас орж байна (АНУ-ын Төрийн Департамент, 2007, 42). 2007 оны илтгэлд тэдгээр орон Tier 3-таа хэвээр үлдсэн ба Tier 3-т орж байгаа орны тоо 16 болж нэмэгджээ. Шинээр орж ирсэн Бахрейн, Кувейт, Оман, Катар зэрэг хэд хэдэн орныг АНУ-ын холбоотон гэж үздэг. 2007 оны илтгэлд тайлбарлахдаа “Сүүлчин хоёр илтгэлтэй адил энэхүү илтгэл хэд хэдэн орныг юуны өмнө гадаадын улирлын ажилчдын дунд гарч байгаа албадан хөдөлмөрлүүлэх зорилгоор хүн худалдаалах явдалтай тэмцэж чадахгүй байгаа учраас Tier 3-т оруулсан байна” гэжээ (*op.cit.*, 30). Энэхүү түүвэр

бичвэрт авч үзсэн найман орноос хоёрыг нь (Австрали, Нэгдсэн Вант Улс) Tier 1-д, дөрвийг нь (Босни ба Герцеговин, Бразил, Нигери, Тайланд) Tier 2-т, нэгийг нь (Энэтхэг) Tier 2-ын хяналтын хуудсанд оруулжээ. АНУ өөрөө tier зэрэглэлд ордоггүй.

Бусад хүмүүс хүний наймаачдын мөрдөн мөшгих буюу хүн худалдаалах явдлыг зогсоох талаар олигтой үйл ажиллагаа явуулаагүй зарим орныг Tier 2 ба 3 зэрэглэлд оруулж чадсангүй гэж АНУ-ын Төрийн Департаментыг шүүмжилжээ. АНУ-ын ойрын холбоотон болох Нэгдсэн Вант Улс хэдэн жилийн турш ээдрээтэй бодлого баримталснаас худалдаалагдсан зарим хүмүүсийг хамгаалалт буюу туслалцаа үзүүлэлгүй орхисон хэрнээ ХХ-ны талаарх илтгэлд Tier 1-д байраа тууштай эзэлсэн байна. Өмнөд Азийн орнуудын tier зэрэглэлийг авч үзэхдээ GAATW-ийн мэргэжилтнүүд Балбын Вант Улс 2005 оны илтгэлд Tier 1-д орж байсан бол бусад жилд нь Tier 2-т орсон байна гэдгийг тэмдэглэжээ. 2005 оны илтгэлд тэмдэглэснээр “бусад салбарт бүтэлгүйтэл байсан хэдий ч Балба улс эдгээр он жилүүдэд хүн худалдаалах явдалтай тэмцэх хүчин чармайлтдаа баттай дэвшил гаргасан” гэжээ (АНУ-ын Төрийн Департамент, 2005, 163). Дараагийн жилүүдэд засгийн газраас хүн худалдаалахтай холбоотой бодлогын чанартай томоохон өөрчлөлт, эрхзүйн шинэчлэл хийгээгүйгээс тус орон 2006 оны илтгэлд зэрэглэл буурахад хүрсэн байна. Гол өөрчлөлт нь улстөрийн өөрчлөлт байлаа. Балба дахь иргэний дайн төгсгөл болж, үе залгамжилсан хааны дарангуйлагч эрх мэдэл хязгаарлагдаж, маогийн талыг баримтлагчид багтаж орсон олон намын засгийн газар байгуулагдав. 2006 оны Илтгэлд зэрэглэл буурсны ганц тайлбар нь Балбын Засгийн газар авилгалын эсрэг хүчин чармайлтаа сайжруулж чадаагүй явдал юм (АНУ-ын Төрийн Департамент, 2006, 186).

Хүний худалдааны талаарх Илтгэлд шүүмжилсэн засгийн газруудын хариу үйлдэл янз янз байгаа нь илт. АНУ-ын үзэж байгаагаар хүний худалдааг зогсоох талаар бага зүйл хийж байсан засгийн газруудыг сэрээж, ажиллагаанд оруулсан нь нааштай байна. АНУ-ын тайлагналын албанаас ХХИ-ийн үзүүлж буй нөлөөг тоймлож харахдаа Ямайка болон Японы засгийн газрууд ХХИ-д шүүмжлүүлснийхээ хүчинд үйл ажиллагаа явуулж эхэлснийг ажиглаж, “... Японы засгийн газар илтгэлд шүүмжлүүлснийхээ хариуд орох виз олголтоо чангатгаж, хүний худалдааны золиос болж хохирогсодтой

гэмтэн байдлаар харьцахыг болиулсныг” тэмдэглэжээ (US GAO, 2006, 28). Гэхдээ орох виз олголтыг хязгаарлаж багасгасны үр дүн улирлын ажилчдад хүндрэл учирч буй эсэх талаар энд тайлбарлаагүй байна.

Ийм төрлийн хажуугийн нөлөөний талаар тууштай мэдээлдэггүй, хэн ч энэ талаар үг дуугардаггүй ч тэнд амьдарч байгаа хувь хүмүүс үүнээс шууд хохирч байгаа нь үнэн юм. Үүний улмаас АНУ ч, олон улсын аливаа байгууллага ч өөрсдөө сэргийлэх гэж өнгөн дээрээ чармайж байгаа хатуу ширүүн харьцах явдалд хүн худалдаалахын эсрэг арга хэмжээ тэгш дүйж үйлчилж байгаа эсэхэд хяналт тавихад одоогоор оролцоогүй байна. Хүн худалдаалах явдал буюу төрөл бүрийн хэлбэрийн мөлжлөгийг үндэсний түвшинд барьж зогсоох олон төрлийн хүчин чармайлт адилхан учир холбогдолтой. Эдгээр хүчин чармайлт бүтэлгүйтэж байгаа нь ердөө л ХХХХ (TVPA)-ийн шаардлагад үндэслэн Америкийн дипломатуудын санал болгосон шалгуурт нийцэхгүй байгаа учраас тэр юм.

АНУ-ын засаг захиргаан дотор Хүний худалдааны талаарх жил бүрийн илтгэл буюу АНУ-ын дэмжин тэтгэж байгаа хүн худалдаалахын эсрэг арга хэмжээний аль нь чухам ямар бодит нөлөө үзүүлж байгааг зохих ёсоор ойлгохгүй байх шиг байна. Энэ нь худалдаалагдсан хүний тоог цөөрүүлэхэд тэдний оруулж буй хувь нэмэр, тэдгээрийн бусад, илүү сөрөг үр дүнтэй нөлөөлөл аль алинд нь хамаатай. АНУ-ын Засгийн газрын Тайлагналын Албаны тэмдэглэсэнчлэн ХХХХ-2000 нь “хүн худалдаалах явдлаас сэргийлэх, худалдаалагдаж хохирогсодыг хамгаалах, тэдэнд туслалцаа үзүүлэх болон хүний наймаачдыг мөрдөн шалгах талаар АНУ болон бусад орнуудын хүрч байгаа дэвшлийг хэмжин үнэлэхийг АНУ-ын засгийн газрын тусгай комиссоос шаардсан билээ” (*op.cit.*, 25). Гэвч GAO-гийн 2006 оны илтгэлд тэмдэглэсэнээр АНУ-ын засгийн газарт хилийн чанадад тавьж байгаа хүн худалдаалахын эсрэг арга хэмжээний бүхий л нөлөөг үнэлэх боломж олгохуйц үнэлгээний төлөвлөгөө буюу засгийн газрын хэмжээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг хараахан боловсруулж гаргаагүй байна. Тус илтгэлд тайлбарлахдаа:

... Вашингтонд болон орон нутагт ажиллаж байгаа тус агентлагийн албаны хүмүүсийн хэлж байгаагаар хүний наймаачдыг мөрдөн мөшгих, биеэ үнэлэх явдлыг устгах, эдийн засгийн найдвартай боломжийг дээшлүүлэх буюу хохирогсодыг орогнуулах болон

нийгэмд нь буцааж оруулах зэрэг төрөл бүрийн хэлбэрийн хүчин чармайлт ямар хэмжээнд хүн худалдаалах түвшинд нөлөөлж байгаа буюу аврагдсан хохирогсод ямар хэмжээнд дахин худалдаалагдаж байгааг харуулах зүйл бага буюу байхгүй байна гэжээ (*ibid*).

АНУ-д хүн худалдаалахын эсрэг арга хэмжээг засгийн газрын хүн худалдаалахын эсрэг бодлогыг хэрэгжүүлэх ажлыг хариуцдаг засгийн газрын гол байгууллага бус ч системтэй үнэлэх хэрэгцээ шаардлага байгааг хүлээн зөвшөөрдөг. АНУ-ын Засгийн газрын Тайлагналын албанаас 2007 оны долдугаар сард гаргасан илтгэл “Олон улсын төслүүдэд хийх мониторинг ба үнэлгээ хязгаарлагдмал байгаа ч шинжээч мэргэжилтнүүд сайжруулах санал дэвшүүлж байна” гэсэн гарчигтай (US GAO, 2007). Энэ нь, магадгүй, хүн худалдаалахын эсрэг хүчин чармайлт урьдчилан харах аргагүй нөлөөтэй бөгөөд “дагалдах хор хохирлыг” багасгахад үйл ажиллагаа шаардлагатай гэдгийг үнэлэх анхны алхам болно.

Дүгнэлт

Хүн худалдаалахын эсрэг авч хэрэгжүүлж байгаа бодлого ашгийн нь хүртэх ёстой бөгөөд хүний эрхээ бүрэн дүүрэн эдлэж чадах худалдаалагдаж хохирсон тэр хүмүүстээ хор хөнөөл болохоос сэргийлэх, тэдэнд шууд тус дэм үзүүлэх явдлыг хангах үүднээс энэ бодлогод маш олон тооны өөрчлөлт оруулах шаардлага дэлхий нийтээр байгааг энэхүү түүвэр бичвэр харуулж байна. Эдгээр өөрчлөлтүүдийн зарим нь хийгдэх хүртэл худалдаалагдсан хүмүүс энэ нь тэдний дээд эрх ашгийн төлөө биш байх гэж эргэлзсээр хүний худалдааны хохирогч гэж тодорхойлогдохгүй байхсан гэж хүссээр байх болно.

Мэдээж, хүн худалдаалахын эсрэг бүтэц худалдаалагдсан хүмүүст нэг их сайн зүйл авчраагүй бөгөөд шилжин суурьшигчид болон бэлгийн ажил эрхэлж байгаа эмэгтэйчүүдэд ихээхэн хор хохирол учруулсан гэж бидний өмнөх дүгнэлт тодорхой өөрчлөлтүүдийг эрэлхийлэх замаар засгийн газрын хүн худалдаалахын эсрэг стратегийг туршин шалгах, үүнийг шинэчлэн өөрчлөх зохистой эсэх талаар хүний эрхийн төлөө аянд оролцогчдод асуудал дэвшүүлж байна. Худалдаалагдах өндөр эрсдэлд байгаа тэр хүмүүсийг хүний эрхээ бүрэн дүүрэн эдлэх боломжтой болгох нь бүхэлдээ өөр хандлага шаардах бөгөөд энэ нь байдлыг сайжруулах, оролцоог нэмэгдүүлэхэд гол анхаарлыг шилжүүлж байна.

Гэхдээ зөвхөн ганц байдал сайжруулах зорилтод анхаарал хандуулах нь хүний эрхийг ноцтой зөрчих явдал багасахгүй хэвээр үргэлжлэх боломж олгоно гэсэн үг юм. Тэгвэл нааштай өөрчлөлт болон байдал сайжруулахыг хамгаалан дэмжих явдлыг худалдаалагдсан болон бусад хүмүүст одоо учруулж байгаа хор хохирлыг багасгахуйц тодорхой өөрчлөлт, шинэчлэлтийг засгийн газрын хүн худалдаалахын эсрэг арга хэмжээнд хийх шаардлагатай хослуулсан хоёр замт хандлага баримтлах нь амин чухал юм шиг санагдана.

Энэхүү түүвэр бичвэрийн тус тусдаа бүлгүүдэд тодорхойлсон хийх шаардлагатай өөрчлөлтүүд тийм олон болохоор бүгдийг нэг дор базаж дүгнэхэд бэрх. Бүлгүүдэд санаа өгсөн арван алхам энд буйг тэдгээрийн төгөлдөр бус байдлыг олж тодорхойлох, засч залруулах үүднээс орон бүр авч хэрэгжүүлэх шаардлагатай.

- 1. Нотолгоонд үндэслэсэн арга хандлага ашиглах.** Энэхүү түүвэр бичвэрийн бүлгүүд хүн худалдаалахын эсрэг арга хэмжээг батлан хэрэгжүүлэхдээ нотолгоонд үндэслэсэн арга хандлага ашиглах болон авах арга хэмжээ нь гарч болох хүний эрхийн хортой зөрчилд дүйцсэн бөгөөд зохистой байх явдлыг хангах нь чухал болохыг илтгэн харуулж байна. Хийж болох дүгнэлт гэвэл “нэг хэмжээ бүхэнд таарна” хандлага (АНУ-ын засгийн газрын барьж байгаа шугамын дагуу) үйлчлэхгүй байж магадгүй. Ялангуяа, энэхүү түүвэр бичвэрт дурдсан орон бүхэнд, юуны өмнө доромжилсон хатуу ширүүн харьцааны бүхий л хэлбэрээр ашиглахаар хүмүүсийг *элсүүлж* байгаад анхаарал хандуулахаасаа өмнө албадан хөдөлмөрлүүлэх тохиолдол болон боолчлон зарцлах маягийн үйл ажиллагаанд илүүтэй анхаарах нь чухал байхсан. Учир нь энэ нь олон шилжин суурьшигчдад сөрөг нөлөөтэй арга хэмжээг батлан авч хэрэгжүүлэхэд хүргэж байсан юм.
- 2. Доромжлол, хатуу ширүүн харьцаа амссан худалдаалагдсан хүмүүс болон бусад шилжин суурьшигчдаас,** түүнчлэн хүн худалдаалахын эсрэг болон цагаачлалын эсрэг арга хэмжээний сөрөг муу нөлөөг биеэрээ амссан бусад хүмүүсээс олж **цуглуулсан баримт нотолгоонд тулгуурлан бодлого боловсруулах.** Тухайлбал, албадан хөдөлмөрлүүлэх болон боолчлох маягийн үйл ажиллагаа нийтлэг байдаг гэгддэг салбарт ажилладаг хүмүүсийг (тэднийг гутаан доромжлогдсон хүмүүс гэж харьцах буюу гаргаж болох аливаа

“шийдвэрийн” нэг тал гэж үзэхгүйгээр) эдгээр гэм буруутай үйлдлийг таслан зогсооход туслаж болох арга замыг олж тодорхойлоход татан оролцуулах. Ерөнхийдөө энэ нь ийм хүмүүсийг засгийн газрын бодлогын объект (болон ихэнхдээ хохирогч)-оос түүний субъект, төр засгийн байгууллагуудад ажиллаж буй хүмүүстэй хамтрагч, ерөнхийд нь хэлбэл ядуу амьдралтай хүмүүс, тухайлж хэлбэл шилжин суурьшигч эмэгтэйчүүдийн бодит амьдралын талаар ойлголт муутай санаа сайт хүмүүсийн хэт удаан боловсруулж байсан тэр бодлогыг хэвшүүлэхэд туслаж чадах түнш болгоно гэсэн үг юм.

3. **Хүний эрхийн үндэсний байгууллагууд хүн худалдаалахын эсрэг арга хэмжээ ямар нөлөө үзүүлж буй талаарх мэдээллийг идэвхтэй цуглуулах болон тэдгээр нь дүйлгэн тэнцвэржүүлэх зарчимд нийцэж буй эсэхийг үнэлж байвал зохино.** Тэд хууль сахиулах байгууллага болон төрийн бусад албан хаагчдын зүгээс хүний эрхийг хэрхэн хүндэтгэж буйг хөндлөнгөөс хянахад оролцохын зэрэгцээ хүн худалдаалахын эсрэг арга хэмжээ хүчинд автаж биеэ үнэлж буй хүмүүсийг олох нэрээр дэн буудлын газруудад хийгдсэн гэнэтийн үзлэг шалгалт, дайралтад өртөж хохирсон бэлгийн ажил эрхлэгчид мэтийн тодорхой бүлгийн хүмүүст хор хохирол учруулахыг багасгахад тусгай заавар, удирдамж байх шаардлагатай эсэхийг үнэлж тогтоох учиртай.
4. **Худалдаалагдсан хүмүүст нөхцөл тулгах буюу хууль сахиулагчидтай хамтран ажиллахыг зөвшөөрснийг нь үндэслэж туслалцаа үзүүлдэг практикийг болиулах.** Энэхүү түүвэр бичвэрт дурдсан аль ч оронд худалдаалагдсан болон хүнд доромжлол, хатуу ширүүн харьцааны золиос болсон хүмүүст хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудтай хамтран ажиллахыг зөвшөөрсөн нөхцөлд туслалцаа үзүүлэх талаарх хууль тогтоомж юмуу хууль сахиулах байгууллагын тогтсон журмын дагуу эдлэх ёстой эрхийнхээ дагуу үйлчилгээ авах болон хамгаалалт эдлэх ёстойг урьдчилан сануулдаг. Ийнхүү нөхцөл, шаардлага тулгадаг нь хүний эрхийг хүндэтгэн хамгаалах хандлагад харш бөгөөд хаа сайгүй үүнийг таслан зогсоох алхам хийх ёстой. Ашиг сонирхол нь юуны түрүүнд хүний наймаачдыг баттайгаар яллан шийтгэх явдал байдаг хууль сахиулах

байгууллагууд мэдээж гэмт хэргийн золиос боллогчид болон гэрчийн этгээдүүдийн аюулгүй байдлыг баталгаатай хангах болон хэрэгцээтэй үйлчилгээг нь үзүүлэхийг хүсдэг бөгөөд энэхүү хандлага нь хүн худалдаалагчдыг мөрдөн шалгахад шаардагдах нотлох баримт олох боломжийг нэмэгдүүлж байна уу, эсхүл хасч байна уу гэдгийг хянаж чадахсан билээ.

5. **Худалдаалагдсан гадаад хүмүүсийн тус оронд түр буюу байнга оршин суух эрхтэй холбоотой хууль тогтоомжийг хууль сахиулах байгууллага болон цагаачлалын албад хэрхэн хэрэгжүүлж буйд хяналт тавих.** Улс орондоо үлдэж хоцрох эрхтэй холбоотой хуулийн заалт байдаг, үгүй ч ийм хяналт хаа сайгүй хэрэгтэй. Хууль сахиулах байгууллагын ажилтнууд худалдаалагдсан хүмүүсийг тэр бүр зөв олж тогтоож чадахгүй буюу тэднийг уг нутгаас зайлуулах, эсхүл хамгаалалт буюу туслалцаа үзүүлэх ёсгүй гэсэн ангилалд оруулж буй бол түүнийг засч залруулах арга хэмжээг засгийн газар авч хэрэгжүүлбэл зохилтой. Олон улс оронд гадаадын эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд болон хүүхдүүдийн хэргийг хянан шийдвэрлэх системийг тэднийг мөрдөн шалгах ажиллагаанд туслалцаа үзүүлж, хамтран ажиллах хүсэлтэй эсэхээс нь үл хамааран туслалцаа авах эрх бүхий буруу харьцаа, хүчирхийлэлд өртөн хохирогч гэсэн байдлаар өөрчлөх хэрэгтэй юм шиг байна.
6. Босни ба Герцеговиний тухай бүлэгт дурдсанаар хууль сахиулах байгууллагаас *de jure* саатуулан хорьсон, эсхүл ТББ-аас *de facto* саатуулсан, мөн Тайландын нийгмийн халамж, хамгааллын байгууллагуудаас тийм байдлаар хорьж саатуулсан шиг **худалдаалагдсан хүмүүсийг хорьж саатуулахыг зөвшөөрсөн бүхий л хууль тогтоомж, журам, зааврыг хүчингүй болгох.** Нигерийн хувьд хэрэг хянан шийдвэрлэх систем нь юуны өмнө худалдаалагдсан хүмүүсийг тэднийг худалдсан сэжиг бүхий этгээдүүдтэй нэг дор хорьж саатуулах (буюу үнэндээ хорих газрын нэг хэлбэр болох “аюулгүй албадан саатуулах” нэртэй аль нэгэн газарт)-гүй байх хэрэгтэй байгаа юм.
7. **Засгийн газрууд худалдаалагдсан хүмүүст орогнол хүсэхэд нь саад тотгор тавихгүй байх,** мөн худалдаалагдаж нэг орноос нөгөө

оронд очиж буй хүмүүст энэхүү сонголт болон мөрдөх журмыг танилцуулах явдлыг хангах ёстой.

8. **Засгийн газруудыг хариуцлагыг дээшлүүлж, тэднээс худалдаалагдсан байж болох хүмүүсийг эх нутагт нь буцаахын өмнө болон буцаах зорилгоор нутагт нь учирч болох эрсдэл болон аюулгүй байдал хэр байгааг үнэлэх ажиллагаа, дүрэм журмаа эргэж харахыг шаардах.** Энэ нь эдгээр хүмүүс нутагтаа эргэж очмогц дахин хохирол амсах (буюу бузар булайгаараа дуудуулах) буюу өөр бусад тохиолдолд эдлэх ёстой эрхээ эдэлж чадахгүйд хүрэх магадлал үгүй болгоход туслах учиртай.
9. **Худалдаалагдсан гэж өөрсдийгөө үзэж байгаа болон худалдаалагдаж ирсэн орондоо орогнох байранд түр хугацаагаар амьдарч байгаа гадаадын хүмүүст эх нутагтаа эргэж очмогц туслалцаа авах боломж бий талаар мэдээлэх.** Нутаг буцаахын өмнө тэдэнд эх нутагтаа очоод зохих туслалцаа үзүүлэх өөрийн нь орны ямар төрийн бус байгууллагатай хэрхэн харилцах талаар зөвлөгөө өгвөл зохино. Ингэхдээ хэрвээ тэд хүсэхгүй бол нутаг орондоо өөрийн байгууллагуудтай харилцахыг хүчлэн шаардах хэрэггүй. Тодорхой хоёр орны хооронд дамжин худалдаалагдсан гэх тодорхой үндэслэл байгаа бол тус хоёр орон нь туслалцаа үзүүлэх асуудлыг харилцан зохицуулах хүчин чармайлт гаргах ёстой. Энэ нь тухайн хоёр орон нягт хамтран ажиллаж байгаа эсэхээс шууд шалтгаалахгүй, харин хоёр орны ТББ-ууд хоорондоо хэрхэн ойр дотно хамтран ажилладагтай холбоотой болно.
10. **Засгийн газрууд өөрийн оронд түр хугацаагаар ажил эрхлэхээр ирж байгаа өөр орны ажилчдад чөлөөтэй эвсэлдэн нэгдэх эрх чөлөөгөөг боон хаагдуулах болон үйлдвэрчний байгууллагад элсэн орох юмуу тийм байгууллага байгуулахад алив тээг тавих арга хэмжээг цуцлах ёстой.** Тэд улирлын чанартай ажил эрхлэхээр орж ирсэн хүмүүс санал өгөх, ажил олгогчид буюу төр, засгийн байгууллагуудын зүгээс орноосоо хөөн гаргах вий гэж айж эмээх зүйлгүйгээр мөлжигдөж буй тухайгаа гомдоллож чадахуйц байдлыг хангах арга хэмжээ авах ёстой. Энэ нь эргээд нэн тэргүүнээ хууль бус шилжин суурьшихыг хориглох цагаачлалын бодлого болон хүний эрх

зөрчигдөх явдлыг болиулах гэсэн хүн худалдаалахын эсрэг буюу албадан хөдөлмөрийн эсрэг бодлого хоорондын илт зөрчилдөөнийг зохицуулан шийдэхэд засгийн газруудад туслах учиртай гэсэн үг юм. Хөдөлмөр эрхлэх эрхийг хамгаалагчид нь өөрсдөө аль ч салбарт гарч байж болох албадан хөдөлмөр болоод боолчлол маягийн нөхцлийг илрүүлэхэд, мөн түүнчлэн доромжлол, хатуу ширүүн харьцаанд өртсөн хүмүүсийн хохирлыг арилгуулах хүчин чармайлтыг дэмжихэд илүү идэвхтэй үүрэг гүйцэтгэх ёстой. Чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрхээ эдэлж буй шилжин суурьшигчид болон бэлгийн ажил эрхлэгчид мэтийн гадуурхагдсан бүлэг хүмүүст учирч буй саад бэрхшээлийг үгүй болгох нь үнэхээр хүмүүсийн байдлыг сайжруулах, засгийн газрын дэмжлэг тусалцаатайгаар эрхээ эдлэх боломжийн орчинг бүрдүүлэх чиглэл дэх эхний алхам юм.

Бусад хаа нэг газраас илүүтэй хүн худалдаалахын эсрэг хүчин чармайлтад засгийн газраас илүү их мөнгө зардаг АНУ-д гэхэд US GAO сургамж авах, хөтөлбөрүүдийг сайжруулахын тулд хүн худалдаалахын эсрэг хөтөлбөр болон төслүүдийн үзүүлэх нөлөөг илүүтэй сайн үнэлэх явдал бол нэг чухал хэрэгцээ хэмээн тодорхойлсон байна.

Гэхдээ АНУ-д болон өөр бусад газарт баримт нотолгоонд үндэслэсэн арга хандлагыг хүлээн авч баримтлахад үзэл суртлын тээг саад байгаа бөгөөд засгийн газрын түвшинд хүн худалдаалахын эсрэг зарим арга хэмжээний бэлгийн ажил эрхлэгчид болон албан бус секторт ажиллаж буй бусад хүмүүст үзүүлж буй сөрөг нөлөөг зохих ёсоор анзаарч үзэх хүсэл зориг байхгүй нь илт байна. АНУ-д бэлгийн ажлыг гэмт хэрэгт тооцохгүй буюу түүнийг хууль ёсны болгохын эсрэг кампани хүчтэй өрнөж байгаа бөгөөд эмэгтэйчүүдийг худалдаалахыг таслан зогсоох хүчин чармайлт гол төв нь байх ёстой гэж шаардаж байна. Иймд хүний эрхийн байгууллагууд болон засгийн газрын бусад агентлагууд хүн худалдаалахын эсрэг арга хэмжээний үзүүлж буй нөлөөг хянан үзэж, шинэчлэлт өөрчлөлтийг санал болгохыг хүлээх нь хангалттай биш байна. Хүн худалдаалахыг зогсоохын төлөө үйл ажиллагаа явуулахыг шаардахад гол үүрэг гүйцэтгэж байгаа хэн ч гэлээ (сүүлийн жилүүдэд мянга мянган ТББ үүнд нэгдсэн) энэхүү үйлст нэмэр хандив болох, өөрсдийн засгийн газрыг илүү хариуцлагатай ажиллахыг шахаж шаардах үүрэг хүлээж байна.

НҮБ Хүн худалдаалахын эсрэг Протокол баталснаас хойш долоон жил өнгөрлөө. Өнөөдөр бүх түвшинд хүн худалдаалахын эсрэг явуулж буй үйл ажиллагаа, түүний үр нөлөөг үнэлж дүгнэсэн хариуцлагатай цаг үе тохиож байна. Энэхүү түүвэр бичвэр хүн худалдаалахын эсрэг арга хэмжээний үзүүлж буй сөрөг нөлөөнд хэтэрхий анхаарлаа төвлөрүүлж, ололттой сайн талыг нь магтан дуулж чадсангүй гэж зарим тайлбарлагч хэлэх вий. Баримт материалыг бодитойгоор шүүн тунгаах замаар авч явуулж буй арга хэмжээнд бие даасан үнэлгээ дүгнэлт өгсөн нь түүний нааштай болоод сөрөг нөлөөг тодорхойлж чадсан гэж үзэж байна. Мөн сөрөг нөлөөг олж тодорхойлох явдал ялангуяа олон нийттэй харилцах харилцааны “гайхамшигийг” өөрийн ололт амжилт болгох чадвартай байгууллагуудын зүгээс ихээхэн хүч чармайлт гаргахыг шаардаж байна. Үнэлгээний мэргэжилтнүүдэд зориулсан гарын авлага (*Impact Assessment for Development Agencies, Learning to Value Change, Oxfam GB with Novib, 1999*) мониторинг болон үнэлгээний ажил хариуцсан хүмүүс өөрсдийн үнэлж буй хөтөлбөрүүд ямар сөрөг үр нөлөө үзүүлж байж болохыг нэг биш хоёр ч удаа эрж хайх шаардлагатай гэж зөвлөж байна. Хүн худалдаалахын эсрэг хөтөлбөрүүд, түүнчлэн хөгжлийн санаачилгуудын хувьд ашиг тус горилсон хүмүүс гол нь тэдэнд туслах хөтөлбөрүүдийг гаргадаг хууль сахиулах албаны хүмүүс, ТББ-ын ажилтнууд болон бусадтай дандаа эрх мэдлийн тэнцүү бус харилцаатай байдаг билээ. Тиймээс тэд аливаа зүйлийг шүүмжлэхээсээ эмээдэг. Гарын авлага зөвлөж буйгаар:

Сөрөг үр дүнтэй өөрчлөлтийг бүр цаанаас нь барьж авч, энэ талаар хэн юу хэлж өгч чадах вэ гэдгийг олохыг эрмэлз. Эдгээр хүмүүс нь ялангуяа эмэгтэйчүүд, үндэсний цөөнх буюу төсөлд хамрагдаж чадаагүй хүмүүс байж болох юм (Roche, 1999, 52).

Энэхүү түүвэр бичвэр нь хүн худалдаалахын эсрэг санал санаачилгуудын авчирсан сөрөг өөрчлөлтүүдийн талаар мэдээ материал цуглуулж, дүн шинжилгээ хийх үйл явцад хийсэн зөвхөн эхний алхам юм. Гэхдээ тус бичлэгийн бүлгүүдэд харуулсан баримт нь хүн худалдаалахын эсрэг өнөөгийн арга хэмжээнүүдэд олон өөрчлөлт хийх нь зүйтэй гэдгийг нотолж байна.

¹ Principle 3 of the UN High Commissioner's *Recommended Principles on Human Rights and Human Trafficking*, Addendum to the Report of the United Nations High Commissioner for Human Rights to the Economic and Social Council, UN document E/2002/68/Add.1.20 May 2002. The Recommended Principles and Guidelines were accessed on 1 May 2007 at www.ohchr.org/english/about/publications/docs/trafficking.doc.

² *Ibid.* Principle 1.

³ The full text of the UN Trafficking Protocol was available in April 2007 at <http://www.ohchr.org/english/law/pdf/ptotocoltraff.pdf>.

⁴ *The Convention for the Suppression of the Traffic in Persons and the Exploitation of the Prostitution of Others* was accessed on 25 February 2005 at <http://www.unhchr.ch/html/menu3/b/33.htm>

⁵ This is in contrast to cases involving children under 18, for in their cases, whenever intermediaries or pimps recruit children to earn money for them from commercial sex, the case comes under the definition of trafficking in the Trafficking Protocol, whether their recruitment and subsequent employment involves any coercion or not.

⁶ Report of the *Ad Hoc* Committee on the Elaboration of the *Convention against Transnational Organized Crime* on the work of its first to eleventh sessions. Interpretative notes for the official records (*travaux préparatoires*) of the negotiation of the United Nations Convention against Transnational Organized Crime and the Protocols thereto, UN document A/55/383/Add. 1, 3 November 2000, page 12, paragraph 64.

⁷ Accessed on 26 April 2007 at www.globalrights.org/site/DocServer/IHRLGTraffickingStandarts.pdf?docID=204

⁸ Guideline 3 of the UN High Commissioner's *Recommended Principles on Human Rights and Human Trafficking*, op.cit.

⁹ UNICEF's *Guidelines for Protection of the Rights of Child Victims of Trafficking* were initially designed especially for South-Eastern Europe (2003). The original version was accessed at www.seerights.org. In 2006, a set of revised Guidelines were issued to be applicable to the entire world. These were accessed at www.unisef.org/ceecis/media/1231.html.

¹⁰ UNHCR document HCR/GIP/06/07, 7 April 2006, accessed on 9 May 2007 at www.unhcr.org/doclist/publ/3d4a53ad4.html.

¹¹ The Council of Europe Convention was accessed on 10 May 2007 at www.coe.int/t/dg2/trafficking/campaign/Source/PDF/Conv_197_Trafficking_E.pdf.

¹² IOM, *The Mental Health Aspects of Trafficking in Human Beings. A set of Minimum Standards*, completed by Arpad Barath, Anjali Da Victoria Lobo, Ruhija Hoxha-Beganovic, Philip D. Jaffe, Nnette Motus, Istvan Szilard, Diana Tudorache, Rossanka Venelinova, and Jacqueline Weekers, Budapest, 2004. The minimum standards are supported by a training guide: IOM, *The Mental Health Aspects of Trafficking in Human Beings. Training Manual*, completed by Arpad Barath, Edward Hauff, Philip D. Jaffe, Gyongy Jakab, Nnette Motus, Istvan Szilard, Diana Tudorache, Rossanka Venelinova, and Jacqueline Weekers, Budapest, 2004.

¹³ IOM Handbook was accessed on 28 May 2007 at <http://www.iom.int/jahia/webdav/site/myjahiasite/shared/shared/mainsite/published/docs/books/CT%20handbook.pdf>.

¹⁴ The BHO Recommendations were accessed on 9 May 2007 at www.who.int/gender/documents/en/final%20recommendations%2023%20oct.pdf

¹⁵ Paragraphs 14 and 15 of the Human Rights Committee's General Comment 27 (Freedom of Movement, Article 12 of the *International Covenant on Civil and Political Rights*) UN Document CCPR/C/21/Rev.1/Add.9 (1999)

- ¹⁶ UN *Convention on the Rights of the Child*. Adopted by UN General Assembly Resolution 44/25 of 20 November 1989, entry into force 2 September 1990. The text of the Convention was accessed on 20 June 2003 at [www.unhcr.org](http://www.unhcr.org/refworld/doc/3a68428d.html)
- ¹⁷ Committee on the Rights of the Child, General Comment № 4 (2003), Adolescent health and development in the context of the *Convention on the Rights of the Child*, UN Document CRC/GC/2003/4, 1 July 2003.
- ¹⁸ Paragraph 27, Committee on the Rights of the Child, General Comment № 6 (2005), “Treatment of unaccompanied and separated children outside their country of origin”, adopted during the Committee’s 39th session, 17 May to 3 June 2005. General Comment № 6 was accessed at www.ohchr.org/english/bodies/crc/docs/GC6.pdf.
- ¹⁹ Workshop on Measurement and Human Rights, July 6-8, 2006, Carr Center for Human Rights Policy, in collaboration with the Program in Criminal Justice Policy and Management Kennedy School of Government, Harvard University. Accessed on 15 May 2007 at www.ksg.harvard.edu/cchrp/programareas/impact.php.
- ²⁰ *The International Convention for the Suppression of the Traffic of Women of Full Age*, adopted by the League of Nations in 1933, required all states ratifying the Convention to prohibit, prevent and punish the trafficking of Women for the purposes of prostitution, even when done with their consent. Earlier, in 1910, the *International Convention for the Suppression of White Slave Traffic* had imposed an obligation on ratifying states to punish anyone who recruited the girl who was below the age of majority into prostitution, whether it was with her consent or not (Weissbrodt and Anti-Slavery International, 2002,19).
- ²¹ Adopted by UN General Assembly resolution 40/34 of 29 November 1985. Accessed on 16 May 2007 at www.ohchr.org/english/law/victims.htm.
- ²² An IOM Training Manual notes that, “even when relatively “safe” and out of the traffickers’ clutches, trafficked persons are generally observed to be anxious, frightened, and in a confused state. They are also often suspicious of any assistance provided, and worry about what awaits them from the time of their escape/rescue, during their stay at the transit center up to the return home... Additionally from a mental health angle, an almost exclusive contact with the authorities (e.g. arrest, evidence giving, testifying in a criminal proceeding) may have negative psychological effects on a trafficked person. She/He may experience memory lapse, fear of law enforcement officials and deep insecurity about the future” (*The Mental Health Aspects of Trafficking in Human Beings, Training Manual*, compiled by Arpad Barath et al., Budapest, 2004, page 39)
- ²³ Asia-Pacific Forum of National Human Rights Institutions, Regional Workshop on Human Trafficking and National Human Rights Institutions: Cooperating to End Impunity for Traffickers and to Secure Justice for Trafficked People, Sydney, Australia, 20-30 November 2005.